



СОЁМБО



БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТӨВ ХЭВЛЭЛ

2020.12.17 №50 (10727)

Үнэ 500 төгрөг

— Дугаар эрхэлсэн ахмад Д.МЭНДБАЯР



✓ Илүү ухамсартай
✓ Илүү хариуцлагатай байцгаая!

ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДЫН НИЙГМИЙН АСУУДАЛД АНХААРЧ БАЙНА

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, хурандаа Ж.Даваарагчаа тэргүүтэй удирдлагууд тус дүүргээс 2020 оны хоёрдугаар ээлжээр хугацаат цэргийн албанд татагдсан дайчдын ар гэрийнхний нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд тодорхой зорилтот бүлгийн иргэдэд нүүрс болон хүнсний бүтээгдэхүүн олголоо. Энэ нь хугацаат цэргийн алба хаагчдаа сэтгэл хоёрдолгүйгээр албан үүргээ гүйцэтгэн цэргийн эрдэмд шамдах хүсэл эрмэлзлэлийг нь дэмжиж байгаагийн тод жишээ хэмээн тодотгож болно.

Хурандаа Ж.Даваарагчаа "Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабаас хугацаат цэргийн алба хаагчдын гэр бүлд халамж, үйлчилгээ үзүүлэх тодорхой бодлого барьдаг. Энэ



хүрээнд Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газраас хугацаат цэргийн алба амжилттай хааж байгаа алба хаагчдын гэр бүл буюу зарим зорилтот бүлгүүдэд нүүрс, хүнсний хангамжийг хүргэх ажлыг зохион байгууллаа. (Үргэлжлэл нь II нүүрт)

АРТИЛЛЕРИЧИД АВАРГАА ТОДРУУЛАВ

Зэвсэгт хүчний артиллерийн мэргэжлийн офицер, ахлагч, цэргийн гэрээт албаны түрүүч, байлдагч нарын дунд "Артиллерийн буудлага, гал удирдах бэлтгэлийн аварга-2020" уралдааныг хоёр үе шаттайгаар зохион байгууллаа. Уралдааны нэгдсэн дүнгээр офицеруудын төрөлд тэргүүн байрт дэд хурандаа М.Эрдэнэтөгс (186), хоёрдугаар байрт дэд хурандаа Г.Баярхүү (167), гуравдугаар байрт дэд хурандаа Д.Төмөрхуяг (120) нар шалгарсан бол ахлагч нарын төрөлд ахлах ахлагч П.Жавхлантөгс (123), сургагч ахлагч

Ч.Лхагважав (016), сургагч ахлагч Д.Дагважамц (120) нар шалгарч бусдыгаа манлайлав. Харин цэргийн гэрээт алба хаагчдаас Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн түрүүч Б.Отгондаваа бусдыгаа тэргүүлсэн юм.

Түүнчлэн орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны болон Артиллерийн цэргийн түүхт 100 жилийн ой 2021 онд тохиож буйтай холбогдуулан артиллерчин дайчдын дунд "Артиллерийн олимпиад" тэмцээнийг ирэх жилийн эхээр зохион байгуулахаар төлөвлөөд байна.

50 САЯ ТӨГРӨГИЙН ХАНДИВЫГ ГАРДУУЛЛАА



"Монгол цэргийн нэгдсэн холбоо"-ноос дэлхий дахинд "Ковид-19" цар тахал голомтлон тархснаас хойш нэг жил орчмын хугацаанд хандив болон хүмүүнлэгийн арга хэмжээг тасралтгүй зохион байгуулсаар ирсэн юм. Харин энэ удаа цар тахлын голомтод ажиллаж, үүргээ чадварлагаар биелүүлж буй эмч, сувилагч, эмнэлгийн ажилтнуудад сэтгэлийн дэм, ажилд нь тус болох үүднээс бэлтгэл болон чөлөөнд гарсан ахмадуудаа уриалан хандивын аяныг өрнүүлжээ.

Энэхүү хандивын аянаар нийт 50 сая төгрөг цугларсан бөгөөд Улсын Онцгой комисстэй зөвшилцсөний үндсэн дээр "Монгол цэргийн нэгдсэн холбоо" ТББ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга, бэлтгэл дэслэгч генерал Ц.Тогоо, удирдах зөвлөлийн дарга, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Энх-Амгалан нар тус хандивыг Цэргийн төв эмнэлэгт гардуулан өглөө. Энэхүү үйл ажиллагаанд Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, Цэргийн төв эмнэлгийн Гэмтлийн эмнэл зүйн төвийн дарга, дэд хурандаа Т.Сүхбаатар болон бусад албаныхан оролцсон юм. "Монгол цэргийн нэгдсэн холбоо" ТББ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга, бэлтгэл дэслэгч генерал Ц.Тогоо "Өнөөдөр бид бүхэн Цэргийн төв эмнэлгийн алба хаагчдын ачааны хүндээс бага ч болов үүрэлцэх

зорилгоор хандивын аяныг зохион байгуулж, улмаар тодорхой хэмжээний мөнгөн тусламжийг үзүүлж байна. Тус эмнэлэг олон жилийн турш тогтвортой үйл ажиллагаагаа явуулж буй туршлагатай. Ер нь цэргийн эмч, сувилагч нар эх орныхоо өмнө өргөсөн тангарагтаа үнэнчээ баталж ямар ч хүнд, хэцүү нөхцөлд үүрэг гүйцэтгэх чадвартай байдаг. Тиймээс ч тэдний сэтгэл санаа, үйл ажиллагааг дэмжих нь бидний үүрэг юм. Цар тахал хэдийнээ дотооддоо тархсан энэ цаг үед хүн болгон хариуцлагатай байх ёстой. Өөрөөсөө гадна гэр бүл, ойр дотнынхоо хамгаалах зайлшгүй шаардлага тулгарч байгаа. Манай холбооноос ямар ч үед эвтэй, хүчтэй байх, бие биеэ урмын үгээр дэмжиж байхыг Монголын ард түмэндээ уриалж байна. Энэ аюулт өвчнийг давж чадна гэдэгт итгэлтэй байна" гэв. Харин Цэргийн төв эмнэлгийн төлөөлөл болох тус эмнэлгийн Гэмтлийн эмнэл зүйн төвийн дарга, дэд хурандаа Т.Сүхбаатар "Цар тахалтай тэмцэхэд зориулж манай эмнэлэгт шаардлагатай тусламжийг үзүүлж байгаад туйлын баяртай байна. Өнөөдрийн байдлаар Цэргийн төв эмнэлэг 1600 орчим хүнийг хүлээн аван тусгаарлаж, тэдгээрийн 60 гаруй хүнд мэс заслын тусламж, үйлчилгээг үзүүлсэн. Одоогоор манай эмнэлэгт 213 өвчтөн эмчлэгдэж байна" гэв.

ШУУРХАЙ БҮЛЭГ АЖЛАА ДҮГНЭЛЭЭ



Улсын Онцгой комиссын 2020 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн 40 дүгээр тушаалаар шуурхай бүлгийг байгуулжээ. Тус бүлэг нь "Ковид-19" цар тахлын сэжигтэй тохиолдлуудыг тусгаарлан ажиглах байруудад үзлэг, шалгалтыг хийж, дүгнэлт гаргах зорилготой аж. Улсын Онцгой комиссын Шуурхай бүлгийг Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай ахлан ажиллаж байгаа бөгөөд Цагдаагийн Ерөнхий газрын Нийтийн хэв журмыг хамгаалах газрын дарга, цагдаагийн хурандаа П.Эрдэнэбат, Онцгой байдлын Ерөнхий газрын Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн дарга, хурандаа Г.Баяр-Эрдэнэ, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн тархвар судлаач, их эмч М.Цолмон, Тагнуулын Ерөнхий газрын хэлтсийн дарга, хурандаа О.Адъяа нарын бүрэлдэхүүн Улаанбаатар хотод байрлалтай, цар тахлын сэжигтэй тохиолдлуудыг тусгаарлан ажиглах нийт 16 байранд үзлэг, шалгалтыг хийлээ. Тэгвэл Шуурхай бүлгийн бүрэлдэхүүн энэ долоо хоногийн Даваа гарагт цахимаар хуралдаж тэдгээр байруудад хийсэн үзлэг, шалгалтаа эцэслэн дүгнэв. Бүлгийн ахлагч, Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай хурлын төгсгөлд "Энэ сард дөрвөн нислэгээр 700 орчим иргэн эх орондоо газардана. Тэдгээр иргэдийн аюулгүй байдлыг хангаж ажиллах нь бидний үүрэг. Улсын Онцгой комиссын Шуурхай бүлгийн гишүүд тусгаарлах байруудад ажиллаж өөрсдийн чиглэлийн хүрээнд үнэлэлт, дүгнэлтийг хийсэн. Хамгийн гол нь тусгаарлах байруудад тавьж буй шаардлагыг бүрэн хангасан байх ёстой. Үүнд бид хяналт тавин ажиллалаа" гэсэн бол бусад гишүүд өөрсдийн санал, санаачилга, үнэлэлт, дүгнэлтийг уламжилсан юм.

А.Уртнасан: АРХИВЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА НЭГДСЭН ТОГТОЛЦООТОЙ БОЛСОН

Шинэчлэн батлагдсан Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс улс орны хэмжээнд дагаж мөрдөгдөж байгаатай холбогдуулан Батлан хамгаалахын төв архивын ахлах зааварлагч-арга зүйч А.УРТНАСАНТАЙ ярилцлаа.

Монгол Улсад Архивын тухай хууль анх хэдийд батлагдан мөрдөгдсөн бэ? Энэ хуулийн ач холбогдлын талаар дурдвал ...

Монгол Улсын архивын салбарын харилцааг зохицуулсан анхны хууль 1998 онд "Архивын тухай хууль" нэртэйгээр батлагдаж, нийтэд үйлчлэх хугацаандаа найман удаа нэмэлт, өөрчлөлт орсон. Энэхүү хууль хэрэгжих хугацаанд улс орны хөгжил дэвшилтэй холбоотойгоор архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд гарч байсан асуудлууд, ялангуяа албан байгууллагууд үйл ажиллагаандаа мэдээллийн технологийг түлхүү ашиглах болсноор шинэ харилцаа үүсэж, тэдгээрийг зохицуулж буй зохицуулалтыг шинэчлэх зүй ёсны шаардлага бий болсон. Иймээс архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг архивын салбарын мэргэжилтнүүд нэгтгэн дүгнэсний үндсэн дээр Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн төслийг боловсруулан өргөн барьсныг Улсын Их Хурал 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцэн баталсан бөгөөд энэ сарын 1-ний өдрөөс үйл ажиллагаандаа мөрдөж эхлээд байна.

Уншигчдад шинэ хуулийн онцлог, ач холбогдлын талаар товч танилцуулна уу?

Энэхүү хууль нь долоон бүлэг 51 зүйлтэй, Монгол Улсын Үндэсний архивын сан хөмрөгийн баримтыг бүрдүүлэх, бүртгэх, хадгалах, хамгаалах, хяналт тавих, ашиглах болон албан хэрэг хөтлөлтийг зохион



хууль, тогтоомж, дүрэм, заавар, журмыг салбарын хэмжээнд хэрэгжүүлэх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэд нь хяналт тавих явдал юм. Урьдчилсан байдлаар шинэчлэн батлагдсан хуулийг энэ сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан хуулийн тухай танилцуулгыг бэлтгэж, цахим сүлжээг ашиглан Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Төрийн цэргийн командлалууд, нийслэл, дүүрэг, аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабуудад хүргүүлсэн. Цаашид хуульд нийцүүлэн гаргах эрх зүйн баримт бичгүүдэд салбарын онцлогийг тусгасан заалтууд оруулах талаар анхаарч холбогдох саналуудыг хүргүүлэн хөмрөг үүсгэгч анги, байгууллагуудад сурталчлан

хувьд салбарын хэмжээнд Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн дагуу сан хөмрөг үүсгэгч анги, байгууллагуудын

архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг ахлах зааварлагч-арга зүйч, сан хөмрөгийн эрхлэгч нарын бүрэлдэхүүнтэй явуулдаг. Цаашид хяналт шалгалтын ажлыг явуулахдаа шинэчлэн батлагдсан хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.15-д "Салбар архивын болон хөмрөг үүсгэгч байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хяналт тавих, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах" хэмээн заасныг удирдлага болгоно.

Хяналт, шалгалтын ажлын үр дүн, ач холбогдол, хөмрөг үүсгэгч байгууллагуудад гарч байгаа нийтлэг алдаа, дутагдал, хүндрэлтэй асуудлуудыг тухайд та юу хэлэх вэ?

Хяналт, шалгалтын үр дүн, ач холбогдлыг нь авч үзвэл энэхүү ажлыг 2013 оноос хойш тасралтгүй зохион байгуулж байгаа бөгөөд сан хөмрөг үүсгэгч нийт анги, байгууллага бүрэн хамрагдсан. Зарим нэг сан хөмрөг үүсгэгч анги, байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд ахиц гарахгүй, салбарын онцлогоос шалтгаалан архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтан нь тогтвор суурьшилтай ажиллахгүй байгаа нь гол асуудал болж байна. Мөн цалингийн шатлал, архив, бичиг хэргийн зардал бага байдаг зэрэг нөлөөлөх хүчин зүйлүүд байгаа нь ажиглагдсан. Нийтлэг гарч байгаа асуудлуудад хэвлэмэл хуудасны зөрчил маш их, зохих зөвшөөрөл авч хэвлүүлээгүй, зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийн стандартыг мөрдөөгүй, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад баримт бичгийн нэр, төрлийг бүрэн тусгадаггүй, үүнээс гарах хор уршгийг тооцоолдоггүй гээд нэрлээд байвал алдаа, дутагдал гарч байна. Гэхдээ хяналт, шалгалт тогтмол болсноор тодорхой түвшинд ач холбогдол өгч, өндөр үнэлэгдэж байгаа анги, байгууллагыг дурдах нь зүйтэй болов уу. Тухайлбал, Хуурай замын цэргийн командлал, түүний харьяа анги, салбарууд өөрсдийн хөрөнгө мөнгөний асуудлыг шийдэж архивын өрөөнд зориулалтын нягтруулсан шүүгээ, дохиолол, хамгаалалтын систем, камерын асуудлыг шийдэж хадгалалт, хамгаалалтыг сайжруулан, тушаал, холбогдох баримтыг скайнардаж цахим архив үүсгэсэн. Батлан хамгаалахын сайдын 2004 оны 226 дугаар тушаалаар баталсан "Түүх, түүхчилсэн лавлах бичих заавар"-ын дагуу ангийн түүхийг чанартай, үр өгөөжтэй бичиж Төрийн архивд шилжүүлсэн. Мөн архив, бичиг хэргийн ажилтнуудыг мэргэшүүлэх сургалтад хамруулсан гээд олон талаар ололттой ажилласан Батлан хамгаалах яамны харьяа Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулга, Барилга захиалагчийн алба, Зэвсэгт хүчний 011, 013, 150, 167, 336 дугаар ангиудыг нэрлэж болно.

Ж.ЁНДОН АГСНЫ ХӨШӨӨТ ЦОГЦОЛБОРЫН АЖИЛД ХАНДИВ ӨРГӨЛӨӨ

Монголын төр, цэргийн зүтгэлтэн, Чөлөөлөх дайнд оролцсон ахмад дайчин, БНМАУ-ын Батлан хамгаалах яамны нэгдүгээр орлогч бөгөөд Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, Цэргийн Ерөнхий дээд сургуулийн захирал, Хүндэт харуулын анхны дарга зэрэг нэр хүндтэй бөгөөд хариуцлагатай албан тушаалуудад үүрэг гүйцэтгэж, олноо "Жагсаалч, рапорт Ёндон" хэмээн алдаршсан хурандаа генерал Ж.Ёндонгийн гавьяаг мөнхжүүлэн, алдаршуулах зорилгоор түүний төрсөн нутаг болох Сүхбаатар аймгийн Баруун-Урт хотноо "Хурандаа генерал Ж.Ёндонгийн дурсгалын хөшөөт цогцолбор"-ыг босгож байгаа юм. Энэхүү бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгийг хандив, тусламжийн хэлбэрээр бүрдүүлж байгаа бөгөөд уг ажлыг эрчимжүүлэх зорилгоор Батлан хамгаалах,

Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд хандаж гаргасан уриалгыг Зэвсэгт хүчний Жанжин штабын генерал, офицер, ахлагч нар манлайлан сэтгэлийн хандив өргөлөө. Зэвсэгт хүчний цөөнгүй ангийн удирдлага, хамт олон болон УБХИС-ийн үе үеийн төгсөгчид, зарим офицер, ахлагч, ажилтан албан хаагчид хандивын гараа сунгасаар байна.

Тухайлбал, Зэвсэгт хүчний 123, 167, 186, 234, 311, 327, 331, 336 дугаар ангиудын удирдлага, хамт олон, ЦЕДС-ийн Ерөнхий цэргийн ангийн 1980, 1992 оны төгсөгчид хандив өргөжээ. Түүнчлэн Сүхбаатар аймгийн удирдлага, Ж.Ёндон агсны үр хүүхдүүд, ач, зээ нар, тэдгээрийн найз нөхөд, генералын цэрэг явсан залуус гээд цөөнгүй хүн чамгүй хандив, тусламжийг өргөснөөр дурсгалын хөшөөт цогцолбор барих зардлын 50 гаруй хувь нь бүрдээд байна.

ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДЫН НИЙГМИЙН АСУУДАЛД АНХААРЧ БАЙНА

(Түрүүч нь I нүүрт)

Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газраас жил бүр хугацаат цэргийн алба хааж буй дайчдынхаа ар гэрийг дэмжих зорилгоор эмчилгээний төлбөр шаардлагатай ар гэрийнхэнд нь мөнгөн тусламжийг үзүүлж ирсэн. Ер нь хугацаат цэргийн алба хаагчдынхаа гэр бүлд төрөл бүрийн дэмжлэг үзүүлэх ажлыг тогтмол зохион байгуулдаг гэв. Энэ үеэр зарим хугацаат цэргийн алба хаагчдын ар гэрийн төлөөллийн сэтгэгдлийг сонслоо.

11 дүгээр хорооны иргэн Э.Баясгалан: Хүү маань Зэвсэгт хүчний 336 дугаар ангид алба хаадаг. Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар болон Цэргийн штабын ажилтан алба хаагчдад талархаж байгаагаа илэрхийлэе. Цар тахлын хүнд үед ийнхүү нэн шаардлагатай хүнсний бүтээгдэхүүнийг өрхүүдэд тарааж байгаа нь нүдээ олсон арга хэмжээ болжээ гэж бодож байна.

11 дүгээр хорооны иргэн Д.Оюунчимэг: Хугацаат цэргийн албанд татагдсан залуусынхаа ар гэрийг дэмжиж байгаа Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын хамт

олонд баярлалаа. Та бүхний ажилд өндөр амжилт хүсье. Хүү Ш.Ариунбаяртаа цэргийн эрдэмд шамдан суралцаж алба сайн хаагаарай. Цэргийн алба хаана гэдэг ирээдүйдээ оруулж буй том хөрөнгө оруулалт шүү гэж дамжуулъя.

12 дугаар хорооны иргэн О.Балдандорж: Хэнэр бид хоёр отгон хүүгээ цэрэгт мордуулаад багагүй хугацаа өнгөрч байна. Хүү маань Дотоодын цэрэгт алба хааж байгаа. Ханьтайгаа хоёулаахнаа үлдсэн хэдий ч нэг жилийн алба нүд ирмэхийн зуур хурдан өнгөрөх байх. Ихийг сурч мэдээд, цаашид өрх гэрээ тэргүүлэх "том" хүн болохоор цэргийн албанд мордсон доо хүү минь. Алба нэр төртэй хаагаад ирээрэй гэж хүсье. Миний хувьд Ардын Армийн бэлтгэл офицер. ЕБС-иудад цэрэгжлийн багшаар ажиллаж байсан. Тэр ч утгаараа Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг байнга дэмждэг. Өнөөдрийн арга хэмжээг зохион байгуулсан Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар, түүний харьяа Цэргийн штабын бие бүрэлдэхүүнд талархаж байна.

Редакцын шууданд

016 дугаар нэгтгэл

2020 онд цэргийн жинхэнэ албанд татагдан ирсэн хугацаат цэргийн алба хаагчдаа цэргийн хэргийн мэдлэг олгохоос гадна хувь хүний хөгжлийг нь дэмжсэн арга хэмжээнүүдийг шат дараатай хэрэгжүүлж байна. Үүний нэг нь хүүхэд, залуучуудад цэрэг-эх оронч үзлийг төлөвшүүлж, цэрэг дайчдаараа бахархаж сэтгэлгээг нь нэмэгдүүлэх зорилготой "Би байлдагч" шүлгийн уралдаан юм. Уралдаанд 20 гаруй хугацаат цэргийн алба хаагч оролцсоноос байлдагч Д.Лхагвасан "Эр цэрэг" шүлгээрээ тэргүүлсэн бол байлдагч Б.Мөнхтөр "Эх орон" шүлгээрээ удаах байрт, байлдагч Б.Гантулга "Миний эх орон" шүлгээрээ гутгаар байрт шалгарлаа.

Дэслэгч Ц.БАДАМСҮРЭН

327 дугаар анги

2020 оны хоёрдугаар ээлжээр татагдан ирсэн хугацаат цэргийн алба хаагчдаас "үл мэдэгч" 15 байлдагчид бичиг, үсгийн боловсрол олгох сургалтыг 10 дугаар сараас явуулж эхэлсэн бөгөөд ангийн захиралын тушаалаар батлагдсан хөтөлбөрийн дагуу дайчдад монгол хэл, математикийн мэдлэг олгох зорилгоор тус ангийн ахуйн үйлчилгээний төвийн угаач, индүүдэгч С.Шүрэнцэцэг, холбооны зангилгааны тоотын дарга, ахлах ахлагч П.Хүрэлбаатар нар хичээлийг удирдан явуулж байгаа юм. Сургалт ирэх оны 2 дугаар сар хүртэлх хугацаанд явагдах ба суралцагчдын идэвх оролцоо маш сайн байгааг удирдагч багш нар нь онцолж байсан юм. Сургалтыг цар тахлаас урьдчилан сэргийлэх заавар, зөвлөмжийг баримтлан зохион байгуулж байна.

Ахмад Д.ГАНБААТАР

326 дугаар анги

Энэ сарын 9-11-ний өдрүүдэд цар тахлаас урьдчилан сэргийлэх талаар Улсын Онцгой комиссоос өгсөн заавар зөвлөмжийн дагуу тус анги нь 2019-2020 оны сургуулийн жилд хийж гүйцэтгэсэн ажлаа олон хүний бөөгнөрөл үүсгэхгүйгээр тодорхой хуваарийн дагуу танилцуулж, ажлаа дүгнэсэн бол өнгөрсөн Мягмар гарагт захирагчийн орлогч нар ажлаа тайлагналаа. Мөн цар тахлын нөхцөл байдал хүндэрсэн энэ үед тус ангийн эмнэлгийн албанаас цар тахлаас урьдчилан сэргийлэх дэглэмийг хэрэгжүүлэх үүднээс бие бүрэлдэхүүнд амны хаалт, гар ариутгагчаар үйлчлэх зэрэг тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Ахмад Л.ТҮМЭНДЭЛГЭР

336 дугаар анги

Ангийн бие бүрэлдэхүүн нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутгийнхаа амьжиргааны түвшин доогуур иргэдэд чиглэсэн сайн үйлсийн аяныг өрнүүлээ. Тодруулбал, Зүүнбаян тосгоны амьжиргааны түвшин доогуур, өндөр настай, өрх толгойлсон, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг хэд хэдэн айлд тусламжийн гараа сунган хүнсний болон ариутгал, халдваргүйжүүлэлт, эрүүл ахуйн бүтээгдэхүүнүүдийг хандивласан юм.

Дэслэгч Ч.БОДЫГЭРЭЛ

байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад чиглэгдсэн. Хуулийн гол онцлог нь албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг анх удаа хуулийн хэм хэмжээгээр зохицуулахаар тусгасанд оршиж байгаа бөгөөд баримт бичигтэй ажиллах талаар төрийн албан хаагчдын хариуцлагыг дээшлүүлэх, Үндэсний архивын сан хөмрөгт хамаарах баримтын зэрэглэлийг тогтоох, тоо бүртгэл-мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, цахим албан хэрэг хөтлөлт, цахим архивын талаарх хэм хэмжээг шинэчлэх зохицуулалтыг хуульчилснаар архивын үйл ажиллагаа улсын хэмжээнд нэгдсэн тогтолцоогоор явагдах боломж бүрдэж байгаагаараа чухал ач холбогдолтой юм.

Салбарын хэмжээнд хуулийг сурталчлах, хэрэгжүүлэх талаар Батлан хамгаалахын төв архиваас ямар ажлуудыг зохион байгуулахаар төлөвлөж байна вэ?

Батлан хамгаалахын төв архивын үндсэн үйл ажиллагааны нэг чиглэл нь Монгол Улсын Их Хурал, Засгийн газар болон эрх бүхий байгууллагуудаас батлан гаргасан архив, албан хэрэг хөтлөлтөд холбогдох

таниулах, хэрэгжүүлэх, хяналт, шалгалт, сургалт явуулах талаар хийгдэх ажлуудыг тусгайлан төлөвлөдөг байна. Мөн Батлан хамгаалахын сайдын 2004 оны 227 дугаар тушаалаар батлагдсан "Баримт бичиг хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалт"-ыг шинэчлэн боловсруулахаар хөмрөг үүсгэгч анги, байгууллагуудаас санал авах ажлыг зохион байгуулаад байна.

Төрийн архиваас сан хөмрөг үүсгэгч анги, байгууллагуудад явуулдаг хяналт, шалгалтын төлөвлөгөөт ажил хэрхэн явагдаж байгаа талаар уншигчдад мэдээлэл өгнө үү?

Төрийн архиваас явуулдаг хяналт, шалгалтын ажил нь Архивын Ерөнхий Газрын даргын 2009 оны 69 дүгээр тушаалаар батлагдсан "Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналт шалгалтын заавар"-ын 1.6-д зааснаар "Улсын байцаагч нар хөмрөг үүсгэгч байгууллагад гурван жилд нэг удаа хяналт шалгалт явуулсан байна" гэж заасны дагуу явагдаж ирсэн. Төрийн архивын дарга нь Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагчийн эрхтэй байдаг. Манай архивын


ДУГААРЫН СУРВАЛЖИЛГА

САХИЛГА САЙТАЙ ГАЗАР Сайн жишиг тогтдог

Энэ удаа бид Зэвсэгт хүчиндээ хагас зууны түүхийг бүтээлцж яваа Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн талаар өгүүлэхийг зорилоо. Анх 1969 онд Ардын Армийн Жанжин штабын "Радио тусгай төв" нэртэйгээр байгуулагдаж байсан тус ангийн хамт олон өнгөрсөн хугацаанд эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалах үйлсэд жинтэй хувь нэмрээ оруулж, тэргүүний ангийн болзлыг 18 удаа ханган Зэвсэгт хүчний болон Ерөнхийлөгчийн нэрэмжит маршрут тусгай бэлтгэлийн аварга шалгаруулах тэмцээнд өндөр амжилт үзүүлж ирсэн баялаг түүхээрээ бахархдаг юм.

ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ...

Анги руу нэвтрэхийн тулд мэдээж үнэмлэхээ шалгуулаад, дараа нь халуунаа хэмжүүлэх ёстой. Ном ёсоор нь хийж гүйцэтгэв. Үргэлжлүүлээд зориулалтын шингэнээр гараа ариутгаад дотогш нэвтрлээ. Шалган нэвтрүүлэх байрандаа тусгаарлах



Хурандаа Ч.Алтангэрэл

өрөө бэлдсэн нь анхаарал татсан тул нэн түрүүнд цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр тус анги ямар арга хэмжээг авч хэрэгжүүлж буй талаар сонирхсон юм. Дээд шатны байгууллагуудаас ирсэн албан бичиг, заавар зөвлөмжийг ягштал биелүүлэн мөрдөж ажиллаж байгаагийн зэрэгцээ үүн дотроо эрүүл мэндийн хангалтын чиглэлээр зарим ажлыг хэрэгжүүлжээ. Энэ талаарх төлөвлөгөөгөө ч дэлгэрэнгүй танилцуулж, шат дараатай авч хэрэгжүүлсэн арга хэмжээнийхээ тухай ч мэдээлэл өглөө.

Тухайлбал, ангийн байрлалд коронавирусын сэжигтэй тохиолдол илэрсэн үед зохих арга хэмжээг авах үүднээс ангийн эрүүл мэндийн төвд болон шалган нэвтрүүлэх байранд тусгаарлалтын өрөөг бэлдэж, бэлэн байдлыг нь хангасан байна. Тусгаарлах өрөөнүүддээ хамгаалалтын хувцас, хэрэглэл, эм бэлдмэл, ам зайлах шингэн, бусад шаардлагатай нөөцөө татан авчээ. Мөн Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн тусгай салбарууд ч халдвараас урьдчилан сэргийлэх дэглэмийг сайтар сахиулж, дээр дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байгаа талаар онцолсон.

Өөр нэг шинэлэлт зүйл нь цар тахлын үед тусгай үүрэг гүйцэтгэх бүлэг. Тус бүлэг нь 25 хүний бүрэлдэхүүнтэй. Шаардлагатай дадлага, сургуулиудад хамрагдан хамгаалалтын хувцас, хэрэглэлээр бүрэн хангагджээ. Өөрөөр хэлбэл, ямар ч үед үүрэг гүйцэтгэх боломжоор хангагдсан гэсэн үг. Энэ үеэр тус ангийн Эрүүл мэндийн төвийн дарга, их эмч, ахлах дэслэгч Г.Сүлгэмгаа Эрүүл мэндийн яамнаас өдөр бүр хийдэг цар тахлын нөхцөл байдлын талаарх хэвлэлийн хурлын мэдээллийг тэр дарууд нь ангийн бие бүрэлдэхүүнд цахимаар уламжилж байв. Ингэж хэвшээд удаж байгаа гэнэ. Түүнчлэн харуул, хоногийн манаанаас буусан алба хаагчийг ангиас унаа гаргаж гэрт нь хүргэх ажлыг ч санаачилсан гэв. Энэ талаар "Бие бүрэлдэхүүний эрүүл мэндийг сахин хамгаалах, нөгөөтэйгүүр ажилтан, алба хаагчид замдаа саатахгүй, бусдад болон өөрсдөдөө эрсдэл учруулахгүй байхад зохих нөлөө үзүүлдэг" хэмээн тодотгов.

ТЭДНИЙ МИНЬ ТАЛААР ТҮЛХҮҮ БИЧЭЭРЭЙ

Хурандаа Ч.Алтангэрэл тус ангийн захирагчаар томилогдоод удаагүй ч удирдах албан тушаалд ажилласан олон жилийн туршлага, шинийг эрэлхийлэгч байдал нь тус ангийн өнгө төрхийг улам бүр засахад ихээхэн нөлөө үзүүлж байгаад ам сайтай хүн олон аж. Түүнээс ангийн үйл ажиллагаа, хэтийн төлөвийн талаар зарим зүйлийг тодрууллаа.

Тус ангид ирээд та ажлаа юунаас эхэлсэн бэ?

-Ангийн хамт олон, удирдлага, штабын бүрэлдэхүүнтэй хамтран ангийг 2020-2030 он хүртэл хөгжүүлэх ирээдүйн хөгжлийн төлөвлөлтэй хийж Зэвсэгт хүчний Жанжин штабын даргаар батлуулахад бэлэн болсон. Энэхүү төлөвлөлтийн тухайд жижүүрлэлтийн техник хэрэгслийг тоон системийн программын удирдлагатай радиопеленгатор, өндөр мэдрэмж бүхий хүлээн авагч, хэмжилтийн төхөөрөмжөөр сольж шинэчлэх мөн ажлын байрны ая тухтай орчин, нөхцөлийг дээшлүүлснээр хөдөлмөрийн бүтээмжийг өсгөх зэрэг онцлог, давуу талтай. Түүнчлэн алба хаагчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангасан, нөгөөтэйгүүр мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчний жишиг анги, байгууллагын стандартад нийцсэн хүний хөгжлийн орчин бүрдэх зэрэг эерэг үр дүн харагдаж байгаа.

Цэргийн сургалт бэлтгэлийн энэ жилийн онцлог юу байв?

-Дэлхий нийтийг хамарсан цар тахал дэгдэж сургалт бэлтгэлийг явуулахад хүндрэлтэй байгаа боловч бие даалт, бүлгийн дасгалыг цахим хэлбэрээр судлуулж, сар бүр үр дүнг нь тооцож байна. Штабын сургалт бэлтгэлийн тухайд их онцлогтой. Тухайлбал, Сири, Армэн, Азербайжан зэрэг улсад явагдсан дайны туршлага, сургамжийн талаар олон улсын хэвлэлүүдэд нийтлэгдсэн мэдээллийн эх сурвалжийг нэгтгэн үнэлэлт, дүгнэлт хийж, үүнийгээ штабын хэсэгчилсэн болон нэгдсэн дадлага явуулахдаа газар, агаар, далай, сансар, кибер орон зайд тулгуурласан платформийг ашиглан, сүлжээ төвтэй дайны онол, арга зүйг судлан мэдээллийн давамгайллыг бий болгохоор зорьж байна. Үүний дүнд өөрийн холбоо, мэдээллийн нэгдсэн сүлжээг эсрэг талын кибер халдлага, дайралт, нисэгчгүй нисэх хэрэгслийн галын цохилт, радио электрон тэмцлийн даралт, саатуулгаас хамгаалах техникийн болон зохион байгуулалтын арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэхэд орчин үеийн дэвшилтэт програм хангамжуудыг ашиглаж, удирдлагын тогтолцооны найдвартай ажиллагааг хангахад онцгой анхаарч байна. Мөн 2020 оны ажлын гол зорилтоо жижүүрлэлтийн үүрэг гүйцэтгэлтийн хандлага, үр дүнг дээшлүүлэн шинэ шатанд гаргаж, Зэвсэгт хүчний Жанжин штабын цогцолбор шалгалтад амжилттай бэлтгэж, Зэвсэгт хүчний тэргүүний ангийн болзлыг хангах, 148 дугаар тусгай салбарынхаа 50 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх, "Сансар" хотхоны хашааг шинэчлэн засварлах зэрэг ажлыг хийхээр төлөвлөөд байна.

Тэрээр ийн яриад үргэлжлүүлэн хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, ололт амжилтын эзэд нь ангийн нийт бие бүрэлдэхүүн гэдгийг тэмдэглээд тэдний төлөөлөлтэй уулзаж, санал хүсэлтийг нь сонсоорой гэлээ.

ШИНЭ САНАА, ШИНЭЛЭГ БҮТЭЭЛ

Захирагчийнх нь захисан ёсоор та бүхнийг тусгай техникийн ашиглалтын инженер, ахлах дэслэгч Ж.Бямбадоржтой уулзуулж байна. Түүнийг ажил үйлсээрээ хамт олноо манлайлсан шинийг эрэлхийлэгч гэдгээр нь ангийнхан нь итгэл хүлээлгэж Зэвсэгт хүчний тэргүүний офицерт өрсөлдүүлж байгаа талаар хурандаа Ч.Алтангэрэл онцлоод амжсан. Үе тэнгийн офицер, ахлагч нар нь ч "Манай Бямбаа олон талын чадвартай мундаг залуу" гэж ам булаалдах юм билээ. Ахлах дэслэгч Ж.Бямбадорж радио телеграфын автомат төхөөрөмжийг зохион бүтээснээрээ тэргүүний офицерт өрсөлдөж шангаа татжээ. Одоо туршилт, судалгааг нь эрчимжүүлж, хэрхэн сайжруулах талаар нь анхаарч ажиллаж байгаа гэнэ. Энэхүү төхөөрөмжийнхөө талаар эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд ч хэвлүүлээд амжсан байна.

"Дэлхий ертөнцөд техник, технологийн хөгжил асар хурдацтай явагдаж байна. Зэвсэгт хүчний хэмжээнд инженер, техникийн мэргэжилтэй цэргийн алба хаагчид дотооддоо өөрсдийн нөөц бололцоог ашиглан техник, технологийн шийдэл, инновацийн бүтээлийн туршилт явуулах замаар тулгамдаж буй зарим зэвсэг, техникийн асуудлуудыг шийдэх, шинэчлэлт хийх, хөгжүүлэх нь нэн чухал ач холбогдолтой" хэмээгээд тодорхой үндэслэлүүдийг ч тайлбарлаж өглөө. Энэхүү төхөөрөмжийн давуу талуудыг нэрлэвэл, овор хэмжээ бага, авч явахад хялбар, харьцангуй хямд төсөр, тэжээл маш бага зарцуулдаг, хэрэглээд хялбар, ойлгомжтой, хөдөлмөрийг үлэмж хөнгөвчилсэн зэргийг дурдаж болно.

Сонирхуулахад, жижүүрлэлт болон радио телеграфын мэдээг олон цагаар нэвтрүүлж хүлээн авснаар цэргийн алба хаагчдын хувьд цахилгаан соронзон орны сөрөг нөлөөлөлд ихээхэн өртдөг аж. Үүний улмаас тархи, толгой өвдөж, мэдрэлийн ядргаанд орох, үс цайрах шинж тэмдэг



Ахлах дэслэгч Ж.Бямбадорж

илэрдэг байна. Харин энэхүү төхөөрөмжийн тусламжтай телеграфын ажиллагааг бүрэн автоматжуулснаар телеграфчид мэдээг компьютерт оруулж, улмаар мэдээний утгыг хэвлэхдээ станцыг олон цаг чангаа суух шаардлагагүй болох юм. Ингэснээр дээр хөндөгдсөн эрүүл мэндийн асуудалд ч эерэг өөрчлөлтүүд бий болох ач холбогдолтой аж.

ШТАБ БОЛ АНГИЙН УУРАГ ТАРХИ

Үүний дараа ангийн штабын дарга, дэд хурандаа Б.Сэр-Одын ажлын өрөөнд түр саатлаа. Тэрээр өдөр өдрийнхөө ажлуудыг

ханын самбарт дугаарлаж тэмдэглэдэг юм байна. Биелснийг нь зөвлөөд, үгүйг нь чагталдаг. Энэ өдрийнх нь ажлын жагсаалт самбар дүүргэж харагдана лээ. Гэхдээ биелсэн нь хавьгүй олон. Үнэхээр ч тэмдэглэж авахгүй бол хүнд мартаж, санах үе бишгүй л бий гэдгийг уншигч та надаар хэлүүлэлтгүй мэдэх биз. Энэ үед дэд хурандаа Б.Сэр-Од доороосоо зургаа дахь ажлыг зөвлөөд биелсэн гэж үзлээ.

Тус анги өнгөрсөн сургуулийн жилд "Цэргийн сургалт бэлтгэлээр хүн нэг бүрийн бэлтгэлжилтийг нэмэгдүүлэн, албан тушаалын үүргээ мадаггүй биелүүлэхэд сурган дадлагажуулах, удирдлага, штабын бэлтгэл, салбаруудын үүрэг гүйцэтгэх чадавхыг дээшлүүлж, бэлэн байдлыг хангах" зорилгыг дэвшүүлжээ. Үүнийгээ хангаж тус сургуулийн жилд штабын бэлтгэлийг хангах сургалтад түлхүү анхаарч удирдлага, штабыг цагийн байдлын ямар ч нөхцөлд богино хугацаанд шийдвэр гаргах, байлдааны ажиллагааг төлөвлөж зохион байгуулах, штабын гар нийлэмжтэй ажиллагааг дээшлүүлэн штабын дадлага, команд штабын сургуулиа өндөр



Дэд хурандаа Б.Сэр-Од

түвшинд зохион байгуулсанд алба хаагчид сэтгэл хангалуун үлдсэн тул энд зорилууд тэмдэглэв. Харин энэхүү амжилтаа бататгаж, ахиулахаар "2020-2021 оны сургуулийн жилд "Удирдлага, штабын ангийн гүйцэтгэх үүрэгтэй уялдуулан үндсэн болон бусад хуулиар хүлээсэн үүрэг гүйцэтгэх томилгоот бүлгүүдийг жигдрүүлэн, зэвсэглэл, техникийн бэлэн байдлыг ханган, үүрэг гүйцэтгэх бэлтгэлжилтийг дээшлүүлэх" зорилгыг цэргийн сургалт бэлтгэлдээ дэвшүүлэн төлөвлөгөөт ажлуудыг шат дараатай хэрэгжүүлж байна" гэдгийг дэд хурандаа Б.Сэр-Од тодотголоо. Ажил албаных нь талаар тодруулахдаа дэд хурандаа Б.Сэр-Одтой богино хугацаанд ч болов танилцлаа. Тэрээр ОХУ-ын Санкт-Петербург хотын Цэргийн холбооны академид магистрын зэргээ хамгаалж ирээд саяхан тус ангид томилогдсон аж. Тус улсад үзэж харсан, Зэвсэгт хүчнийхээ нэгтгэл, ангидад нэвтрүүлэх гэж бодсон олон ч шинэлэл санаа, санаачилга байгаа талаар их л зүйлсийг ярьж, чих онгойлгох шиг болсон.

Цэргийн тэтгэвэрт гарсан алба хаагчдын хувьд бусад салбарт үргэлжлүүлээд 10-15 жил ажиллах нөөц, бололцоо дүүрэн бий ч саяхныг хүртэл тодорхой хэсэг нь хамгаалагч, харуулчнаар ажилладаг байлаа. Одоо цаг үе өөрчлөгдөж хос мэргэжилтэй бэлтгэл үүрэгтнүүд ажлын талбарт олноор гарах болсон нь сайшаалтай. Тус ангийн тухайд Зэвсэгт хүчний Жанжин штабын орлогч даргын саналыг үндэслэн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Политехникийн коллежтой хамтран хос мэргэжил эзэмшүүлэх зорилгоор зарим, офицер ахлагчийг тогооч, авто техникийн засварчин, барилгын өргөн мэргэжил, гоо сайханч зэргээр суралцуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

ЗҮРХНИЙ ДУУДЛАГАТАЙ АНДУУД

Ажил үйлс, ололт амжилт, бүтээлч сэтгэлгээ, эерэг хандлагаараа онцгойрсон тус ангийн бие бүрэлдэхүүний зарим нь нэгэн ховор тохиолын эзэд байж таарав. Захирагчийн материал хэрэгслийн хангалт хариуцсан орлогч, хошууч Д.Батсүх, ангийн ахлагч, тэргүүн ахлагч П.Мөнхжаргал нар гурав дахь ангид хамт алба хааж байна. Хошууч Д.Батсүхийг анх сургуулиа төгсөөд Зэвсэгт хүчний 119 дүгээр ангид томилогдон очиход нь тэргүүн ахлагч П.Мөнхжаргал байж таарч. Амьдрах байр нь ч нэг болж таарсан гэнэ. Үүний дараа бас л хувь тохиолоор Зэвсэгт хүчний 256 дугаар ангид зэрэг шахам томилогдсон байна. Ингэж явсаар одоо эл ангид хамтдаа алба хааж буй нь бурхны зурсан зураг ч гэмээр. Ийм сонин тохиолын эзэд одоо зүү орох зайгүй нөхөрлөх болсон нь харин өнөөдрийг хүртэл цагийн шалгуурыг хамт давсных гэж тэд дуу нэгтэй хэлэх юм билээ. Энэ зуур цайлж суусан хоёрын яриа өндөрлөж, тус тусын ажилдаа орцгоолоо. Ангийн "Дайчин алдрын танхим"-аар орлоо. Цэцгэн хээтэй гоёмсог улаан хивс дэвссэнээс гадна дугуй хэлбэртэй сүүн гэрлийг таазнаасаа эгц доош унжуулсан нь саруул бөгөөд тохилог орчныг бүрдүүлжээ. Баруун хананд нь ангиасаа төрсөн алдартнуудын зургийг байршуулсан нь нүдэнд тод тусна. Монгол Улсын арслан Д.Ганхуяг, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд асан Ш.Түвэндорж нарын алдартнуудаас эхлээд тус ангийн захирагчаар ажиллаж байгаад БНХАУ-д суух Батлан хамгаалахын аттшегаар томилогдсон хурандаа М.Ганбатын зургийг хүндэтгэлтэйгээр байрлуулжээ. Мөн өнгөрсөн 50 гаруй жилийн түүхийнх нь ололт амжилт, үйлс гавьяаг нь нэг шугаманд цэгцтэй өрсөн цом, өргөмжлөл,

талархлуудаас харж болно.

Тэргүүн ахлагч П.Мөнхжаргал ахлагчийн зөвлөлөөс хийж хэрэгжүүлсэн ажлын талаар мэдээлэл өгөхдөө "Ангийн ахлагч нарын ажиллах, сурч боловсрох ая тухтай орчныг бүрдүүлэх, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх зэрэг зорилт тавин ажиллалаа. Монгол Улсын хууль тогтоомж, удирдлагын баримт бичиг, тушаал, шийдвэрийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд таван зорилтын хүрээнд 37 ажил төлөвлөн хэрэгжүүлж, тодорхой үр дүнд хүрсэн" гэв. Мөн "Монгол цэрэг-Энхийн төлөө" цогцолборын хөшөөнд нийт 2.585.000 төгрөгийн хандив цуглуулан бүтээн байгуулалтын ажилд дэмжлэг үзүүлсэн гэдгийг онцолсон.

АМИН ЧУХАЛ АСУУДЛУУДЫН НЭГ НЬ АР ТАЛЫН ХАНГАЛТ

Захирагчийн материал хэрэгслийн хангалт хариуцсан орлогч, хошууч Д.Батсүхээр ахлуулсан комисс ангийн дулааны шугам сүлжээг "Тамирын цахиур" ХХК-тай хамтран Улаанбаатар хотын төвлөрсөн дулааны системд шинээр холбуулах ажлыг Нийслэлийн хөрөнгө оруулалтаар /239,838,451 төгрөг/ хийж гүйцэтгэн 50 айлын орон сууц болон "Сансар" хотхоны халаалтыг төвлөрсөн дулааны системд тус тус шилжүүлсэн байна. Түүнчлэн албаны 52 өрөөнд 2000 ширхэг секц паар сууриуулан, штабын В1 давхрын дулааны үзелийг шинэчлэн сайжруулж, гадна дулааны шугамын засварт шинээр дөрвөн худаг нэмж гарган, 132 хаалтыг сольжээ. Дулаан явбал мянган лан гэгчээр шугам, сүлжээ холбох ажлыг цаггардуулалгүй хийж гүйцэтгэснээр бие бүрэлдэхүүний тав тухтай орчинд ажиллаж, амьдрах нөхцөл бололцоог эрс сайжруулсныг тэмдэглэх нь зүйн хэрэг юм.

Ангийн үйл ажиллагаатай танилцаж явахад штабын дөрвөн давхарт хөрөөн дуу чахарч, хадаас цохих чимээ дууддав. Үүдээр нь үл ялиг тоос манарч, модны үртэс газраар нэг хөглөрсөн өрөө рүү явж орлоо. Алба хаагдааа зориулж хувцасны шүүгээ урлаж байгаа нь энэ аж. Бүр хүн нэг бүрийнх гэнэ шүү. Ангийн дотоод нөөц бололцоонд тулгуурлан хийж байгаа бөгөөд 2,000,000 төгрөгийг зарцуулжээ. Цар тахлын үед иймэрхүү бүтээлч санал, санаачилга гаргасныг мэдрэмжтэй бөгөөд соргог гэж хэлмээр.

ДАНДАР БААТАР АА! НААД ОХИНОО ӨВӨР ДЭЭРЭЭСЭЭ УНАГАЧИХАВ АА ...

Ахмад Г.Одонтуяа 1996 онд тус ангийн радио чимээний курст элсэн орсон. Дараа жил нь радио спортын III зэргийн болзол хангасан тул энэхүү ангидаа радио телеграфчнаар томилогдсон байна. Гэхдээ цол, "форм"-гүйгээр энэ ангийн хашаанд багагүй хугацааг өнгөрүүлжээ. Ийнхүү 2002 онд дэд ахлагч цолоо авч мөрдэснүүдийнхээ эгнээнд шилжсэн байна. Дараа нь 2007 онд тусгай бэлтгэлийн багшаар офицерын орон тоонд, 2011 онд удирдах байрандаа бүлгийн даргаар тус тус томилогдсон аж. Мөн 2018 онд бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт орж чиглэл хариуцсан ахлах офицероор өнөөдрийг хүртэл ажиллаж байна гэлээ. Ахмад Г.Одонтуяа хэлэхдээ "Энгийнээс цэргийн, ахлагчаас офицер болж дэвшсэн өнгөрсөн хугацаанд өөрийгөө тодорхой хэмжээнд хөгжүүлж, шат ахисан мэдлэг, туршлагыг хуримтлуулсан гэж бодож байна. Тиймээс сүүлийн жилүүдэд үндсэн ажлынхаа зэрэгцээ цэргийн сургуулийн төгсөгчид, шинээр томилогдож ирсэн ахлагч



Ахмад Г.Одонтуяа

нар гээд залуу үеэ сурган дадлагажуулах чиглэлд анхаарах болсон" гэлээ. Үнэхээр ч түүнээс номын дуу сонссон алба хаагчид "Багш аа!" гэж дуудах нь холгүй юм болно. Мөн тэрээр "Анх тус ангид ирэхэд саглаар том мододтой цэцэрлэгт хүрээлэн шиг л санагддаг байлаа. Тэр үетэй харьцуулбал, анги төвийн халаалтад орсонтой холбоотой удирдах байр, офицер, ахлагч нарын ажлын орчин, нөхцөл эрс сайжирсан. Сүүлийн жилүүдэд ангид шинээр томилогдож байгаа цэргийн алба хаагчдын хувьд гадаад хэлний мэдлэг өндөр байна, хоёроос гурван орны хэлээр ярьдаг гэж хэлж болно. Энэ нь том давуу тал. Ийм сайн боловсон хүчин томилогдон ирж байгаад ахмадууд сэтгэл хангалуун байдаг. Ангийн ирээдүй ч улам гэрэлтэй харагдаж байна. Бидний хувьд анги маань хоёр дахь гэр л гэсэн үг. Ийм л сэтгэлээр ажил, албандаа ханддаг. Гэрээ тав тухтай, тохилог, цэвэр байлгахыг хүн бүр хүсэх нь ойлгомжтой шүү дээ" гээд өөрийнхөө амьдралд тохиолдсон нэгэн сонирхолтой түүхээс хуучиллаа.

(Үргэлжлэл нь VII нүүрт)

ТЭМҮҮЖИН

МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт офицер, ахлагч, багш, ажилтан албан хаагч, сурагчид та бүхэнд "Тэмүүжин Өрлөг" сургууль үүсэн байгуулагдсаны 10 жилийн ойн баярын мэндийг дэвшүүлэе.

Батлан хамгаалахын сайдын 2010 оны 79 дүгээр тушаалаар "Тэмүүжин Өрлөг" мэргэжлийн сургалттай ерөнхий боловсролын сургуулийг Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн материаллаг баазыг түшиглэн байгуулж, 2015 онд Батлан хамгаалах яамны хөрөнгө оруулалтаар 6.3 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө бүхий 3 давхар хичээлийн болон дотуур байрыг тоног төхөөрөмжийн хамтаар ашиглалтад оруулсан түүхтэй. Энэ цаг үеэс хойш та бидний сургууль үүсэн байгуулагдаад 10 дахь жилтэйгээ учран золгож байна.

Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалах, Зэвсэгт хүчний залгамж халаа, ирээдүйн боловсон хүчнийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлж, эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилго тавин, нийгэм, цаг үеийн шаардлагад нийцэхүйц жишиг сургууль болгохын төлөө бидний хамт олон чармайн ажиллаж, олон сайхан үр дүн, амжилт бүтээлээр дүүрэн байсныг дурдахад таатай байна.

Цаг цагийн аясад түүхэн намтраа туурвин эх орныхоо ирээдүйн хөгжлийн цөм болсон боловсролын салбарынхаа түүхийг бүтээлцэж буй үе үеийн багш, ажилтан албан хаагчид, эцэг, эх, төгсөгчид, сурагчид, хамтран ажилладаг хамт олон та бүхэндээ ойн баярын мэндийг дахин дэвшүүлж ажилд тань амжилт, амьдралд тань аз жаргал, эрүүл энхийг хүсэн өрөөе.

Номын цагаан буян хурж, эрдэм ухаан дэлгэрэх болтугай.

**"ТЭМҮҮЖИН ӨРЛӨГ" СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ,
ДЭД ХУРАНДАА Д.БАТ-ЭРДЭНЭ**

АЛСЫН ХАРАА

Эх оронч үндэсний үзэл, хүмүүжил, төлөвшил бүхий иргэнийг бэлтгэдэг тогтолцоо бүрдсэн, шилдэг менежменттэй сургууль болно.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Сургалтын ажил, үйлчилгээний чанар, хүртээмжийг эрхэмлэн оюуны өндөр чадавх, бие бялдрын өв тэгш хүмүүжилтэй, эх оронч үзэл бүхий иргэнийг иргэний нийгэм, Зэвсэгт хүчинд бэлтгэхэд оршино.

ТҮҮХЭН ТОВЧООН

2010 он. Батлан хамгаалахын сайдын 79 дүгээр тушаалаар "Тэмүүжин" мэргэжлийн сургалттай цэрэгжсэн ерөнхий боловсролын сургууль байгуулагдав. Нийслэлийн Засаг даргын 2010 оны 435 дугаар захирамжаар "Өрлөг" бүрэн дунд сургууль нэршлээр сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл авав.

2012 он. БНСУ-ын Гёнгү аймгийн сурагчдын төлөөлөл "Өрлөг" сургуулийн үйл ажиллагаатай танилцаж, гадаад харилцааны эхлэл суурь тавигдав. Шинэ сургуулийн барилгын шав тавих ёслол болов.

2013 он. Нийслэлийн Засаг даргын 2013 оны 526 дугаар захирамжаар "Тэмүүжин Өрлөг" бүрэн дунд сургууль болов. БНТУ-ын Цэргийн ахлах сургуульд анхны сурагчид суралцав. Тус сургуулийн сурагчдын сурагчийн тангараг өргөх ёслол анх удаа болов.

2014 он. Ю.Гагарины нэрэмжит "Билгийн үүдэн" сургуультай хамтран ажиллах гэрээг байгуулав.

2015 он. Хичээлийн шинэ байрандаа оров. ОХУ-ын Буриад улсын Кабанск хотын Сухинский дунд сургуультай хамтран ажиллах гэрээг байгуулав. Эх орны дайны ялалтын 75 жилийн ойд зориулсан Ангарск хотын цэргийн ёслолын жагсаалд "Тэмүүжин Өрлөг" сургуулийн сурагчид алхав. ОХУ-ын Шинжлэх ухаан, соёлын төв, Монгол цэргийн музей, "Тэмүүжин Өрлөг" сургууль хамтран хамтын ажиллагааны гурван талт гэрээг байгуулав.

2016 он. Анхны төгсөлтөө хийв. Анхны эмэгтэй сурагчид элсэн оров. Тувагийн Бүгд Найрамдах Улсын Кызыл хотын Кадетын сургуульд долоодугаар ангийн сурагчид суралцахаар явав. Батлан хамгаалахын их сургуулийн 95 жилийн ойн хүрээнд тус сургуулиас төрөн гарсан БНМАУ-ын баатруудын хөшөөт цогцолборыг бүтээв. ОХУ-ын Ангарск хотод цэргийн хээрийн сургалтад 17 сурагч, хоёр сурагч багш хамрагдав. Тус сургуулийн сурагчид Ардын хувьсгалын 95, Тулгар төр байгуулагдсаны 2225, Их Монгол Улс байгуулагдсаны 810 жилийн ойн үндэсний их баяр наадмын нээлтийн баярын жагсаалд оролцов.

2017 он. Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Ц.Элбэгдорж сургуулийн үйл ажиллагаатай танилцав. Сурагчид Ардын хувьсгалын 96, Тулгар төр байгуулагдсаны 2226, Их Монгол Улс байгуулагдсаны 811 жилийн ойн, Төрийн далбааны өдөрт зориулсан ёслолын жагсаалд оролцов. ОХУ-ын Пермь хотод зохиогддог олон улсын кадетын сургуулиудын сонсогчдын "Залуу эх орончдын чуулга уулзалт"-д оролцож эхлэв. Тус сургуулийн сурагчидтай цэргийн анхан шатны бэлтгэл бүхий зуны хээрийн сургалтыг анх удаа зохион байгуулав. ОХУ-ын Ангарск хотын Ерөнхий боловсролын VI дунд сургуулийн урилгаар "Тэмүүжин Өрлөг" сургуулийн офицер, ахлагч, сурагчдын төлөөлөл тус сургуулийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлав. 11^б ангийн сурагч, ахлах түрүүч О.Төгөлдөр "Залуу эх орончдын чуулга уулзалт"-ын үеэр зохион байгуулсан тэмцээний саадтай зурвасын төрөлд дээд амжилтыг 1 минут 27 секундээр шинэчлэн тогтоов. Эрхүү мужийн Ангарск хотын тусгай VI дунд сургуулийн багш, сурагчдын төлөөлөл тус сургуулийн үйл ажиллагаатай танилцав. 11^а ангийн сурагч Б.Ариунсанаа "Кorea Open Memory Championship" ой тогтоолтын тэмцээний "Хийсвэр зураг"-ийн төрөлд дэлхийн шинэ амжилтыг тогтоов.

2018 он. "Тэмүүжин Өрлөг" сургууль "Монгол хурандаа" нийгэмлэгтэй хамтран ажиллах гэрээг байгуулав.

2019 он. Дотоод хэргийн их сургуулийн дэргэдэх Ахлах сургуультай санамж бичгийн хүрээнд хамтран ажиллах гэрээг байгуулав. Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх хичээлийн шинэ жилийн нээлтэд оролцов. ОХУ-ын Эрхүү мужийн Залуучуудын бодлогын яамны сайд А.К Попов тус сургуульд айлчлав.

2020 он. Анхны төгсөгчид их сургуулиа дүүргэж, дэслэгч цолоо гардан, ажил, амьдралын гараагаа эхэллээ. 10^а ангийн сурагч Ж.Тэмүүжин ОХУ-ын Нийгэм, соёл, хүмүүнлэгийн сангаас олгодог "Халуун зүрх" одонгоор шагнагдав.

ТЭМҮҮЖИН ӨРЛӨГ ӨНӨӨДӨР ...



Түүхэн улбаатай Офицерын сургуулийн үргэлжлэл болгон Батлан хамгаалахын их сургуулийн бүрэлдэхүүн сургуулийн нэг болох Цэргийн инженерийн сургуулийн нэгдүгээр давхрын баруун жигүүрт гурван өрөөг засаж тохижуулан сургалтын үйл ажиллагаагаа эхлүүлж байсан нь "Тэмүүжин Өрлөг" сургуулийн эхлэл байлаа. Энэ цагаас хойш "Тэмүүжин Өрлөг"-чүүд нэгэн аравны түүхийг баринтаглалаа. "Монгол Улсын ирээдүйн хөгжилд манлайлан оролцох оюуны өндөр чадавх, бие бялдрын өв тэгш хүмүүжилтэй,

зөв хүмүүжил, төлөвшил бүхий хүмүүнлэг иргэнийг нийгэм, Зэвсэгт хүчинд бэлтгэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн өдгөө 65 багш, ажилтан албан хаагч, 460 сурагчтайгаар сургалтын үйл ажиллагаагаа явуулж байна.

Өдгөө Боловсрол, шинжлэх ухааны яамнаас гаргасан тушаал, журмын дагуу ерөнхий эрдмийн хичээлээс гадна цэргийн анхан шатны мэдлэг олгох сургалтыг амжилттай явуулж байна. Залуу эх орончдын чуулга уулзалт, багш, сурагч солилцооны хөтөлбөр зэрэг олон төсөл, ажлыг амжилттай

хэрэгжүүлж ирсэн бөгөөд тус сургуулийн онцлог, сурагчдын эх оронч үзэл, төлөвшил нь ердийн сургуулийн сурагчдад үлгэр дуурайл болсноор тус сургуульд элсэн суралцагсдын тоо жил бүр нэмэгдсээр байна. Энэхүү сургуулиас сурлага, урлаг, спортоор олон улсад төдийгүй улс, нийслэлд амжилт гаргадаг багш, сурагчдын тоо ч нэмэгдсээр байна. Нийт 5 удаагийн төгсөлтөөр 212 сурагч бүрэн дунд боловсролыг эзэмшсэнээс 78,7 хувь нь гадаадын болон дотоодын их, дээд сургуулиудад суралцаж байна.

ТҮҮХИЙН УЛБААТАЙ ТӨРИЙН СУРГУУЛЬ



1925, 1937 онд тус тус буй болсон Сүхбаатарын нэрэмжит сургуулиудын уламжлалыг үргэлжлүүлж, 1943 онд байгуулагдсан Офицерын сургуулийн залгамж халааг "Тэмүүжин Өрлөг" сургууль хүлээн авсан билээ.

Эр цэргийн төлөвшил, хүмүүжлийг эх оронч үзэл санаа дагалддаг нь жам юм. Цэргийн хүн эсвэл цэргийн суурь төдийгүй анхан шатны мэдлэгтэй хүн хэнийг, юуг, яаж хамгаалахаа мэддэг. Үүрэг, хариуцлага ч өндрөөр ухамсарладаг. Монгол цэргийн хувьд эртний түүх, соёл, монгол үндэстнээ, Монгол Улсаа хамгаалах тангарагтай. Өөрөөр хэлбэл, зөвхөн хүнээ, газар нутгаа хамгаалаад зоосохгүй эртний их өв соёлоо, ирээдүйн оршихуй, хөгжил дэвшлээ тэд давхар хамгаалдаг юм. Энх тайван тогтносон өнөө цагт зэвсэг барин тэмцдэггүй юм гэхэд, оюун санааны бат бэх хана хэрмийг, цэрэг хүн, эх оронч иргэн сүр жавхлантайгаар сүндэрлүүлдэг байх ёстой. Тиймээс ч "цэрэг-эх оронч хүмүүжил" гэж ерөнхийлөн хэлдэг. Эндээс манай улс, үндэстний хөгжлийн, өөрөөр хэлбэл, ард түмний амьдралын энгийн нэг "томьёо" гарч ирнэ. Монгол Улс хөгжил дэвшлээр жигүүрлээ, ард түмэн нь тайван

амгалан, өөдрөг жаргалтай байж гэвэл эх орончид нь олшрох ёстой, эх оронч үзэл санааг түгээн дэлгэрэх учиртай билээ. Өөр зам байхгүй. Учир нь эх орончид олон байх тусам аливаа улс үндэстэн сэргэн манддагийг хүн төрөлхтний түүх өгүүлнэ. Мэдээж хэрэг эх оронч үзэл санааг өндөр боловсрол, мэргэжлийн ур чадвар дагалдах учиртай бөгөөд харин "цэрэг-эх оронч үзэл санаа" нь бүх зүйлийн суурь болдог. Тус сургууль өөрийн онцлог ихтэйгээс гадна өв уламжлалд суурилан төлөвшсөн сургууль юм. Хүүхэд бүрд ерөнхий боловсролыг чанартай эзэмшүүлэхийн зэрэгцээ цэргийн анхан шатны боловсролыг олгодог. Энэ сацуу Монгол Улсын Зэвсэгт хүчний уламжлалт цол, дүрэмт хувцсыг хэрэглэн аравт, гучит, зуут гэсэн зохион байгуулалттайгаар сургалтын үйл ажиллагаагаа явуулдаг. Өөр ямар ч сургуульд ийм жишиг үгүй. Дээр нь монгол бахархал, эх оронч үзэл, төлөвшилд суурилсан оюун ухаан, бие бялдрын өв тэгш боловсролыг олгоход сургалт, хүмүүжлийн ажил чиглэгдэх тул "Тэмүүжин Өрлөг"-ийн бүтээгдэхүүн нь Тэмүүжин өрлөг болон гардаг учиртай. Өнгөрсөн зууны эхэн болон дунд үеийн цэргийн сургуулийн сурагчид юунд зорьж, юунд

бэлтгэгдэж байгаагаа аль эрт мэдэрсэн хүүхдүүд байв. Энгийн сургуулийн сурагчидтай харьцуулахад өсөж торних, сурч боловсрох орчин нь өөр, цаг үе нь одоотой харьцуулшгүй ялгаатай, олон улсын байдлаас шалтгаалаад сонор сэрэмжтэй, хариуцлага өндөртэй байсан тул тэд хожмоо жинхэнэ эх орончид, цэрэг эрс болцгоосон юм. "Тэмүүжин Өрлөг"-ийнхөн ч алтан үеийнхэнтэйгээ адил сэтгэлдээ ганцхан тангараг тээх болно. Тэр нь жинхэнэ эр цэргийн тангараг билээ.

"Тэмүүжин Өрлөг" сургуулийн сурагч би
Төр түмнээ эрхэмлэн
хүндэтгэж
Төрөлх сургуулийнхаа алдар
сууг
Таван тивд өргөн
мандуулахаа
Андгайлан тангараглаж байна
Өнгөрсөн, одоо, ирээдүй
Гурван цагийн хэлхээнд
Өвгөдөөс уламжилж ирсэн
түүх, соёлоо дээдэлж
Өөдлөх ирээдүйг цогцлоон
бүтээх
Өв тэгш иргэн болохоо
Аав, ээж, ачит багш нарынхаа
өмнө
Анд найз, ангийн нөхдийнхөө
өмнө
Тангараглаж байна,
Тангараглаж байна,
Тангараглаж байна.

ӨРЛӨГ

10 ЖИЛ

Анхдагчдын асаасан гал

“СУВОРОВЫН СУРГУУЛЬ ШИГ СУРГУУЛЬ БАЙГУУЛ” ...

2010 оны эхээр Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Ц.Элбэгдорж Батлан хамгаалахын сайд Л.Болд, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, дэслэгч генерал Ц.Бямбажав болон надад цэргийн хагас зохион байгуулалттай, суралцах сонирхол, чадвартай боловч сурах боломжоор хязгаарлагдмал хүүхдүүдэд зориулсан ОХУ-ын Суворовын нэрэмжит Цэргийн сургууль шиг сургуулийг БХИС-ийн дэргэд байгуулах талаар үүрэг, чиглэл өгсөн юм. Үүнийг хэрэгжүүлэх сайдын тушаал ч гарч сургууль байгуулах ажил эхэлсэн. Миний бие захирлын хувьд Батлан хамгаалахын их сургуулийн удирдах зөвлөлийг хуралдуулан сайдын өгсөн үүрэг, чиглэлийг хүргэж, Батлан хамгаалахын их сургуулийн дэргэдэх бүтцийн сургууль болох Цэргийн инженерийн сургуулийн нэгдүгээр давхрыг чөлөөлөн засвар, тохижилт хийж бэлэн болгох, 9 дүгээр сард хичээл эхлэхэд бэлтгэх талаар тодорхой үүргийг өгч байнгын хяналт, удирдлагаадаа байлган тус сургуулийг байгуулалцсандаа бахархаж явдаг. Энэ хугацаанд сургалтын хөтөлбөр, материаллаг баазыг бий болгох, сургуулийн удирдлагыг томилох, бусад ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөртэй дүйцүүлэн цэргийн онцлогийг тусгасан хөтөлбөрийг боловсруулах, Монгол Улсаас бага, дунд боловсролын талаар баримталж байгаа бодлого, хууль, эрх зүйн орчинтой нийцүүлэх, Нийслэлийн болон Баянзүрх дүүргийн Боловсролын газрын холбогдох албаныханд байгуулах гэж буй сургуулийнхаа талаар ойлгуулах, дэмжлэг авах, холбогдох шийдвэр гаргуулах зэрэг маш их ажил, арга хэмжээг авах шаардлага бий болсон. Энэхүү томоохон ажлын ард гарч тус сургуулийн үндэс суурийг нь тавихад Батлан хамгаалахын удирдлагын академийн захирал, хурандаа С.Наранцогт, ахлах багш, хурандаа Я.Мягмарсүрэн, сургалтын менежер Р.Энх-Амгалан, багш У.Тунгалаг-Оюун, үйлчилгээний ажилтан Г.Цэцэгдулам нар ихээхэн идэвх зүтгэл гарган ажилласныг онцгойлон тэмдэглэх нь зүйтэй. Энэхүү цэргийн сургуулийг байгуулж, үндэс суурийг нь тавихад тухайн үеийн Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, хурандаа Ж.Болдбаатар, Батлан хамгаалахын сайдын зөвлөх С.Ганболд, хошууч генерал Б.Эрдэнэбат нар байнга дэмжин хамтран ажиллаж ирснийг дурдахад тааламжтай байна. Цэргийн сургалттай дунд сургууль бий болгох үйл явц нь анх “Офицерын сургууль” нэртэйгээр байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж Монгол Улсад нэр цуутай олон эх орончид, алдартнуудыг бэлтгэж байсан цэргийн түүхэн уламжлалд тулгуурласан юм. Цэргийн сургалттай дунд сургуулийг байгуулсан гол үзэл санаа нь хүүхэд наснаас нь эхлэн цэрэг-эх оронч үзэл, хүмүүжлийг олгох, бие бялдрын өндөр хөгжилтэй, монгол уламжлал, ёс заншлаа мэддэг, эх орноо хайрладаг залуу хойч үеийг бэлтгэх, нэг үгээр хэлбэл, “ясны эх оронч, бие бялдрын хувьд өв тэгш хөгжилтэй, нийгмийн элит болох” залуусыг ирээдүйд бэлтгэх зорилгыг агуулж байсан юм. Тухайн үед сургуулийг байгуулж байхад төсөв, хөрөнгийг нь Батлан хамгаалах яамнаас хуваарилаагүй, өөрийн гэсэн өмч, материаллаг баазгүй хүндхэн байсан бөгөөд бүгдийг нь БХИС-ийн төсөв, материаллаг баазад тулгуурлан зохион байгуулсан ба багш, ажиллагсдынх нь цалинг олгон дэмжлэг үзүүлж байлаа. Цэргийн дунд сургуулийн нэрийн хувьд эхлээд “Өрлөг” гэж нэрлэж байгаад нээлтээ хийж сургалт эхэлсний дараагаар Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржоос сургуулийн



нэршлийн хувьд анхаарах, түүх, уламжлалын талаа бодолцож тусгавал зүгээр гэж зөвлөсний дагуу БХИС-ийн удирдах зөвлөл, “Өрлөг” цэргийн дунд сургуулийн багш нартайгаа ярилцаж байгаад “Тэмүүжин Өрлөг” гэж нэрлэх шийдвэрт хүрсэн юм. Энэхүү сургуулийг бэхжүүлж өөрийн байр, материаллаг баазтай болгох талаар байрлгын зураг, төсвийг нь хийлгэх, түүнийг нь хөөцөлдөж улсын төсөвт суулгах гээд чамгүй ажлыг миний бие гардан хариуцаж байхад одоогийн Ерөнхий сайд У.Хүрэлсүх, тухайн үеийн Сангийн сайд Д.Хаянхярваа, Улсын Их Хурлын Байнгын хорооны дарга Д.Арвин, Батлан хамгаалахын сайд Л.Болд нар сайн ойлгож дэмжлэг үзүүлсний хүчинд энэхүү сургуулийн барилга баригдаж, өөрийн гэсэн хичээлийн орчин үеийн тохилог байртай болсон юм. “Тэмүүжин Өрлөг” сургуулийн төсвийг улсын төсөвт тусгайлан суулгах, эрх зүйн орчныг нь бүрдүүлэх, улсын адил төстэй дунд сургуулиудтай ижил зэрэг зиндаатай болгох, Боловсролын хуулийн дагуу олон янзын нэмэгдэл үйлчилгээг авах, сургуулиа гадаад, дотоодод сурталчлах, гадаад хэлний сургалтыг чанартай зохион байгуулах, сайн багш, ажиллагсадтай болох, цэргийн анхан шатны сургалтыг үндэслэлтэй зөв зохион байгуулах, математик, физикийн сургалтын суурийг сайн тавьж өгөх зэргээр олон асуудлыг анхнаас нь зөв хөгжүүлэхэд тус сургуулийн захирлаар ажиллаж байсан дэд хурандаа В.Дашпунцаг, сургалтын менежер Р.Энх-Амгалан, цэргийн албаны офицер, дэд хурандаа Ж.Пүрэвсүрэн, багш Г.Наранчимэг, У.Тунгалаг-Оюун, Б.Цэцэгмаа нар маш их сэтгэл, зүтгэл гарган ажиллаж байсны үр дүнд өнөөгийн өнгө төрхийг олж, цаашид хөгжих үндэс, дурсамжаар сэргэх түүх тавигдсан гэж үзэх бүрэн үндэстэй. “Тэмүүжин Өрлөг” сургуулийг бэхжүүлэхэд Батлан хамгаалахын үе үеийн сайд нар, яамны удирдлагаас сургалтын материаллаг баазыг нь бүрдүүлэх, эрх зүйн орчныг нь сайжруулах, төгсөгчдийг нь дотоод, гадаадын цэргийн сургуулиудын уралдаант шалгалтад орох нөхцөл боломжийг нь бүрдүүлэх зэргээр байнгын дэмжлэг үзүүлж байсан юм.

БХИС-ийн захирал асан, хошууч генерал З.БОЛДБААТАР

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЗАЛУУ ХАЛАА

Монгол Улсын түүхэн хөгжлийн явцад Ардын цэрэг, хязгаарын цэрэгт хүүхдийн цэрэгжсэн сургууль байгуулагдаж байсан ч янз бүрийн шалтгаанаар тасалдаж, мартагдаж иржээ. Би бээр ОХУ-д аспирантур суралцаж байхдаа Монголын залуу үеийг цэрэг-эх оронч үзэл санаагаар сургаж, хүмүүжүүлэх сургалтын систем байх ёстой хэмээн үзэж хөтөлбөр боловсруулж байсан. “Эх оронч үзэл” нь онолын мэдлэг, бие бялдрын хөгжил, техникийн сэтгэлгээний хөгжлийн нэгдлийг хангасан сургалтын цогцолбор систем боловсруулахыг шаарддаг. Цаашид ийм шаардлага хангасан сургалтын хөтөлбөрөө улам боловсронгуй болгон баталгаажуулж, яамны дэмжлэг туслалцааг авах нь чухал. Бид бүхний бодож боловсруулсан хөтөлбөр нь хуучин офицерын болон ОХУ-ын Кадетын сургалтаас ангидөөрийн онцлогтой. Энэхүү сургалтын чиглэл, зорилго нь сонсогч хүүхдийн онцлог, сэтгэхүйд хүртээмжтэй, ойлгомжтой байсан нь анхны 30 сурлагийн сургалтын явцаас харагддаг. Уг сургалтыг чадварлагаар гардан зохион байгуулж удирдсан багш, бэлтгэл дэд хурандаа Ж.Пүрэвсүрэнгээр бид бахархаж явдаг юм. Түүний онол, дадлага хосолсон сонирхолтой сургалтыг явуулж ирсний үр дүн ч гэж хэлж болно. Анхны цэрэгжсэн сургуулийг зохион байгуулах хөтөлбөрийг боловсруулахад доктор, профессор, хурандаа Х.Шагдар, хурандаа Г.Мягмаржав нарын багш офицерууд ихээхэн дэмжлэг үзүүлснийг ч энд дурсах ёстой. Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд асан Л.Болд, Ж.Энхбаяр нарын улс төрчид асар их дэмжиж байсны ч тэмдэглэх учиртай. Сургуулийг байгуулахад санаачилгатай ажилласан Батлан хамгаалахын сайдын зөвлөх, доктор, профессор, хошууч генерал Б.Эрдэнэбатын гавьяа, зүтгэлийг өндөрөөр үнэлж байна. Энэхүү сургууль байгуулагдсан эхний жил Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд орон нутгийн байгууллагуудаас аймаг, орон нутагтаа салбар сургуулийг байгуулах санал, хүсэлт олноор ирүүлж байсан нь эх оронч сэтгэлгээтэй Монголын ард түмний сэтгэлд нийцсэн, өргөжин тэлэх ирээдүйтэй сургууль болохыг нь нотолдог. БХИС-ийн дэргэд байгуулагдсан ерөнхий боловсролын “Тэмүүжин Өрлөг” бүрэн дунд сургууль маань Зэвсэгт хүчний залуу халааг сургаж бэлтгэх бааз суурийн эхлэл болж буйд анхны захирлын хувьд омогшиж явна. Цаашид эрдэм шинжилгээ, судалгааны ажлаа хөгжүүлж, үндэсний хэмжээний сургууль болгон хөгжүүлэх хүсэл эрмэлзэл багш, ажилчдын сэтгэл зүрхэнд буцалж байдагт баяртай байна.



Та бүхэндээ 10 жилийн ойн мэнд дэвшүүлж, сайн сайхан бүхнийг хүсье.

Түүхийн ухааны доктор, бэлтгэл хурандаа С.НАРАНЦОГТ

ДУРСАМЖ СЭРГЭЭХ ТҮҮХ

ХАР СҮЛДНЭЭ ШИВНЭСЭН ХҮСЭЛ МИНЬ БАГА БАГААР БИЕЛСЭЭР Л БАЙНА

Анхны төгсөгч Э.ЗАНДАНХҮҮ:

“Тэмүүжин Өрлөг” сургууль нь 2010 оны намар захирал, дөрвөн үндсэн багшийн бүрэлдэхүүнтэйгээр Цэргийн инженерийн сургуулийн нэг давхарт үйл ажиллагаагаа явуулж эхэлснийг тодхон санаж байна. Бид анхны 30 сурлагч нь бөгөөд 11 настайдаа цэргийн амьдралын захгүй далайд хөл тавьж байлаа. Хичээлийн шинэ жилийн анхны баяраар бид гучуулаа Батлан хамгаалах яаманд байрлах Бүх цэргийн Их хар сүлдний өргөөнд хүндэтгэл үзүүлсэн юм. Тэр үед Их хар сүлдэндээ шивнэсэн хүсэл минь бага багаар биелсээр л байна. Миний хувьд энгийн хичээлээс илүүтэйгээр цэргийн талын хичээлүүд, өмсөж байгаа хувцас минь сонирхол татдаг байлаа. 9 дүгээр сарын 1-ний өдөр сургуулийн бие бүрэлдэхүүн жагсдаг учир түүнээс өмнө биднийг жигдрүүлэх ажилд сургагч ахлагч Т.Ганболд томилогдож билээ. Тэр үед би жагсаал дотроо “Алив, манайхаан, чанга дэвсээд өг” гэж дуугарсан, сэтгэл хөдлөл ихтэй хүүхэд явсан сан. Удалгүй дэд хурандаа Ж.Пүрэвсүрэн цэргийн алба хариуцсан офицероор томилогдож, “Цэргийн хүн ийм байх ёстой” гэсэн үлгэр дуурайллаар цэргийн эрдэмд сургасан. Цэргийн хувцасныхаа гадуур шинэлийнхээ бүсийг бүсэлсэн, долоо хоног болгон таваг шиг хэлбэрээр үсээ засуулдаг, бие биесээ “Та” гэж хүндэтгэсэн, хичээл тараад жагсаалын талбайд өнжсөн, ботинкны ул тав хоногийн ая даахгүйгээр ханз үсэрсэн тийм л өдрүүд үргэлжилсэн. Цэргийн нэгдсэн дээд сургуулийн сонсогчид биднээс манай сургуулийн талаар их асуудаг. Нэг удаа надаас жагсаалын тодорхойлолтыг асуухад нь жагсаалын 16 тодорхойлолтыг эхнээс нь дуустал үг, үсэг дутаалгүй хэлтэл тэдний нүд нь томорч, мундагийг минь гайхаж билээ. Хөдөө, орон нутгаас ирсэн, бас хол гэртэй хүүхдүүд цэргийн казармд байрладаг байсан. Цэргийн эрдмээс гадна соёл, урлагийн маш олон арга хэмжээнд оролцсон. “Тэмүүжин Өрлөг” хэмээх сургуулийнхаа дууг ангиараа хоолой нийлүүлэн дуулж тайзнаа олон удаа



гарсан. Тайзан дээр гарахын тулд маш олон удаа бэлтгэл хийдэг, хичээл тараад Соёлын төвийн тайзан дээр хоёр эгнээ болж, хоолой салган дуулж оролт, гаралтаа давтан тэр байтугай тайзны соёлд ч маш сайн сурсан юм. Урлагийн үзлэг болох гээд би “Жалам хар” бүжгийг гурван өөр хүнээр заалгаж сурсан. Энэ бүжгээ төгсөн төгстлөө бүжиглэсэн дээ. Одоо ч Оросын Холбооны Улсын Цэргийн их сургуульд Монгол Улсаа сурталчлан бүжиглэсээр л явна. Жил болгон сургуулиа сурталчлах ёслолын ажиллагааг жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулдаг байлаа. Бид сургуулиа сурталчлах хүрээнд бөмбөртэй жагсаалын үзүүлэх тоглолтыг сонирхуулдаг байсан юм. Бөмбөртэй жагсаалын үзүүлэх тоглолт нь дэд хурандаа Ж.Пүрэвсүрэнгийн удирдлага дор манай ангийнхны олон удаагийн бэлтгэлээр бий

болсон юм. Тухайн үед бөмбөртэй жагсаалын үзүүлэх тоглолтыг дарцагтай хийдэг байлаа. Улаан, цагаан дарцага өмднийхөө халаасанд хийгээд олон удаагийн ёслолд оролцон сургуулиа сурталчилдаг байв. Анги ахих тусам үзүүлэх тоглолт маань шинэчлэгдэж, төгсөн төгстлөө үргэлжилсэн ба цаашид ч уламжлагдсан юм. Биднийг суралцах хугацаанд сургуулийн маань танх тэмдэг гурван удаа шинэчлэгдсэн. Анхных нь “Өрлөг” гэсэн бичигтэй цагаан өнгийн дугуй, хоёр дахь нь “Тэмүүжин Өрлөг” гэсэн таван хошуутай, улбар шар өнгөтэй, гурав дахь нь одоогийн танх тэмдэг. Есдүгээр ангид суралцах үеэс бид хээрийн хувцастай болсон. 2012 онд сургуулийн шавыг Батлан хамгаалахын сайд асан Ж.Энхбаяр тавьж, шинэ сургуультай болох эхлэл тавигдсан. Энэхүү баярт үйл явдлыг тохиолдуулан Батлан хамгаалахын сайд Ж.Энхбаяраас Цэцэгмаа, Наранчимэг ангийнханд “Шонхор” зусланд амрах эрхийг өгч билээ. Бид жил бүр сургуулийнхаа шинэ байранд орохыг байнга хүсдэг. Төгсөх ангид орох жил сургуулийн маань шинэ байрны нээлт болж хүсэл минь биелж билээ. 2015 онд Аугаа их Эх орны дайны ялалтын 70 жилийн ойн баяраар бид Эрхүү мужийн Ангарск хотод цэргийн ёслолын жагсаалд орохоор уригдсан юм. Хоёрдугаар сараас эхлэн өдөр болгон жагсаалын бэлтгэл хийнэ. Би жагсаалын үзүүлэх тоглолтыг бөмбөрөөр эхлүүлж, дуусгадаг байлаа. Ялалтын баярын үйл ажиллагааны турш Оросын иргэд биднээр бахархаж, шагшин магтаж байсан нь үнэхээр дурсамжтай. Төгсөлтийн хонхны баярын концертын үеэр Б.Цэцэгмаа багш бидэнд зориулсан шүлгээ уншихад хойно нь зогссон 28 залуу мэлмэртлээ уйлсан, одоо бодоход гэгээлэг, сайхан дурсамж юм даа. Хар багаасаа цэргийн мөрдэс зүүж, хүйтэнд хөрч, халуунд халахдаа жагсаалын алхаа, дарга нарынхаа командаар омогшиж, эх орноо хайрлан, хамгаалах хүсэл эрмэлзэлтэй болсон юм. Монголын шилдэг боловсон хүчин төрөн гарахад эрдэм мэдлэг, оюун ухаанаа харамгүй зориулж байдаг сургуулийн удирдлага, багш, цэргийн албаны офицер, ахлагч нартаа баярлаж явдгаа илэрхийлье.

ТӨРИЙН ГЕНЕРАЛ ҮҮХИЙН БИЧЭЭСТ

Монголчууд бид баялаг түүхэн уламжлалтай. Ийм учир орчин цагийн залуус эх түүхээ шимтэн судалж, эх оронч үзэл гэж юу болох талаар өөрийн биеэр мэдрэх хэрэгтэй. Тэгж гэмээ нь бидний хойч үед энэ улс, үндэстэн бүрэн бүтэн өвлөгдөх учиртай буй заа.

ОРШИЛ

"Монголын түүхийг судалъя гэвэл цэргийн түүхийг нь судал" гэдэг. Тэртээ 2000 жилийн өмнө Төв Азийн өндөрлөгт нүүдэлчдийн соёлыг дархлан, тив, дэлхийг донсолгож байсан Хүннүгийн эзэнт гүрнээс эхлэлтэй бидний монголчуудын цусанд дайчин уламжлал бүрэлдэн тогтож, өнөө цагт өвлөгдөн иржээ. Түүний нэгэн жишээ бол XX зууны эхэнд монгол үндэстнийг хагалан бутаргах зорилго бүхий харийн түрэмгийллийн эзэнт гүрнээс нэгдэж тусгаар улсыг байгуулж чадсан баатар, жанжид юм. Тэдгээр гавьяат үйлстнүүдийн түүхээ нь болж, эх орныхоо төлөө хоёргүй сэтгэлээр зүтгэсэн төр, нийгэм, цэргийн гарамгай зүтгэлтэн бол БНМАУ-ын Ардын цэргийн хэрэг эрхлэх яам (АЦХЭЯ)-ны орлогч сайд асан хурандаа генерал С.Равдан юм. Энэ эрхэм хүний баатарлаг гавьяаг мэдэх тусам "Эх оронч" гэж энэ болохыг илүү ойлгох шиг. Тиймээс түүний талаар бичигдсэн түүхийн үнэт баримтуудыг уншигч танд өгүүлъя.

МАЛЧИН АРДААС МОНГОЛЫН СЭХЭЭТЭН

XX зууны эхэн үе монголчуудын хувьд нэн чухал цаг хугацаа байлаа. Олон арван жилийн харийн түрэмгийлэлд дарлагдаж байсан үндэстэнд тусгаар тогтнол хамгийн чухал асуудалд тооцогдож, Үндэсний эрх чөлөөний болон Ардын хувьсгал зэрэг томоохон үйл явдлууд шил дараалан гарсаар байв. Чухам тэрхүү хүндэн жилүүдэд ард түмэн хувьсгалч,

газар хөл тавьж, үеийн залуустайгаа танилцсан залуу хүү С.Равданд Зөвлөлт Холбоот Улсын Ленинград хотын Дорно дахиныг судлах дээд сургуульд суралцах боломж олджээ. Тэр бээр тэр даруй сургуульд явах сонирхолтой байгаагаа мэдэгдэн 1924 оны өвөл хойд хөршийг зорьсон. Суралцах хугацаандаа Зөвлөлт Холбоот Улсын нэрт монголч эрдэмтэд болох Б.Я.Владимирцов, С.А.Козин, А.В.Бурдуков нараар хичээл заалгах ховорхон завшаан тохиож, Зөвлөлт Холбоот Улсын аж амьдрал, бүтээн байгуулалттай танилцан, ихийг сурч мэдэн эх орондоо 1928 онд эргэн ирсэн аж.

Залуу сэхээтэн С.Равдан 1928-1930 онд Аж ахуйн яаманд хэрэг хөтлөгч, Улсын хэвлэлийн газарт үсэг өрөгчөөр ажиллаж байгаад 1930 оны 8 дугаар сарын 15-ны өдөр цэргийн албанд татагдсан талаар шинжлэх ухааны доктор, профессор, хурандаа Д.Гомбосүрэн түүний мэндэлсний 100 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хуралд тавьсан илтгэлдээ дурдсан юм. Тухайн үед нам, засгийн шийдвэрээр ухаан бодол сийрэг, бусдыгаа манлайлагч, жинхэнэ хувьсгалт тэмцэгч байсан олон залуусыг Зөвлөлт Холбоот Улс руу сургуульд явуулдаг байжээ. Улмаар сургууль төгсөөд ирэхэд нь улс төрийн өндөр албан тушаалд томилон ажиллуулдаг байв. Гэвч нам, засгаас урван тэрсэлсэн, харь орны тагнуулч байх магадлалтай хэмээн тэдгээр боловсон хүчний ихэнхийг нь хэлмэгдүүлсэн нь тэр үеийн улс төрийн хамгийн бусармаг үйлдлийн илрэл болдог. Тэдгээр хэлмэгдэгсдийн дунд С.Равдантай хамт суралцаж байсан олон найз нөхөд нь багтаж, цаазын ял сонсож



6 дугаар сарын 7-ны өдрөөс эхлэн 10 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд бүгд 80 дугаар хэвлэгдсэн. Анх бид Тамсагбулагт сонин гаргаж байсан боловч фронтоос 100 гаруй километр хол, мэдээ, материал авч, сурвалжлах ажил удаашралтай байсан тул 6 дугаар сарын сүүлчээс Хамар давааны нэгэн жалганы окомонд хэвлэн гаргах болсон юм" гэжээ. Тус сонины өрөгчөөр ажиллаж байсан Д.Чимэддорж дурсамждаа "Манай сонины газар нь эрхлэгч С.Равдан, сурвалжлагч Банзрагч, үсэг өрөгч Чойндон, Даваажаргал, хэвлэгч Сэвжид, жолооч Чойжил, Дамдинсүрэн нарын 10 гаруй дарга, цэргүүдээс бүрддэг байлаа. Тэр бээр энэ сониныг гаргахын тулд маш их хүч, хөдөлмөрөө дайчлан ажилласан юм" гэжээ.

Үүнээс үзэхэд цэрэг, дайчдаа зоригжуулж, тэднийг байлдааны улаан шугамд нүүр тулан ирэхэд үгээр хурцалж өгдөг хүмүүсийн төлөөлөл бол "Эх орны төлөө" сонины эрхлэгч

командлалын удирдлагын хамт ихээхэн ажлыг хийж гүйцэтгэжээ. Харин 1950 оноос эхлэн Монгол Улсын гадаад харилцаа, дипломат албанд зүтгэж эхэлсэн байна. С.Равдан нь 1950-1952 онд БНМАУ-аас БНХАУ-д суугаа Элчин сайдын яамны зөвлөх, 1952-1955 онд БНМАУ-аас БНАСАУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд, 1955-1956 онд БНМАУ-ын Гадаад явдлын яамны сайдыг хамаарагч, 1956-1959 онд БНМАУ-аас БНСЧСУ, БНБАУ, БНААУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар томилогдож дипломат албанд нийт 10 жил зүтгэсэн түүхтэй.

Тэрээр дээрх өндөр бөгөөд хариуцлагатай албыг дараалан нэр төртэй хашиж, улс орны гадаад харилцааг хөгжүүлэх, дипломат албыг бэхжүүлэх, боловсон хүчнийг сурган боловсруулахад жинтэй хувь нэмрийг оруулсан байна. Түүний урьд өмнө нь сурч, мэдсэн, хуримтлуулсан туршлага нь тус албанд зүтгэх үндэс суурь нь болжээ. Энэ талаар Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга асан Х.Бэхбат "Элчин сайд С.Равданы дипломат алба хашиж байх үеийн архивын баримт, материалуудаас харахад, тэрээр ажил хэрэгтэй туйлын хариуцлагатай ханддаг, тэсвэр хатуужилтай, нэн ажигч гярхай, сайн удирдан зохион байгуулагч хүн байсан нь тодорхой харагддаг. С.Равдан гуайн энэ бүх чанарыг, түүний олон талт үйл ажиллагааг, тухайлбал, БНАСАУ-ын Элчин сайдаар ажиллаж байсан үеийн зарим эх сурвалжаас иш татах замаар тодруулж үзэх оролдлого хийвэл илүү сонирхолтой байх болов уу. Элчин сайд С.Равдан Монгол болон Ардчилсан Солонгосын харилцааг хөгжүүлэх, дайны үед Ардчилсан Солонгосын

чансааг нь сайжруулахад анхаарсан байдал харагддаг" гэж тэмдэглэжээ. Үүнээс үзэхэд С.Равдан нь Монголын орчин үеийн дипломат албаны түүхэнд нэгэн тод хуудас болон мөнжиж, залуу хойч үедээ үлгэр дуурайл болон үлджээ.

ИРГЭНИЙ ХАМГААЛАЛТЫН ГАЗРЫГ ҮНДЭСЛЭГЧ

Дипломат албанд зүтгэж байсан С.Равдан 1959 онд Ардын цэргийн хэрэг эрхлэх яамны орлогч сайдаар томилогдон 1970 оныг хүртэлх хугацаанд ажиллажээ. Энэ хугацаанд БНМАУ-ын Ардын Сайд нарын Зөвлөлийн 1967 оны 7 дугаар сарын 14-ний өдрийн тогтоолоор дэслэгч генерал цол хүртсэн байна. Тухайн цаг үед дэлхийн улс гүрнүүдийн дунд "Хүйтэн дайн" ид хүчээ авч, БНМАУ-ын гадаад орчин нарийн төвөгтэй болж ирэв. Энэ үед БНМАУ-ын удирдлагаас социалист хамтын нөхөрлөлийн орнуудтай гадаад бодлогоо уялдуулж, улс орны батлан хамгаалах чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн олон арга хэмжээг хэрэгжүүлжээ. Үүний нэг жишээ нь, Улсын Иргэний хамгаалалтын тогтолцоог бий болгосон явдал юм. Улмаар БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1970 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн зарлигаар Улсын Иргэний хамгаалалтын газрыг бие даалган байгуулж, даргаар нь дэслэгч генерал С.Равдан томилогдож, 1972 оны 5 дугаар сард насан эцэслэх хүртлээ удирджээ. Тэрээр тус газрын дарга байх хугацаанд улсын иргэний хамгаалалтын эрх зүйн орчныг бүрдүүлсэн нь энэ чиглэлээр олон зуун боловсон хүчин бэлдэх үндсийг бий болгосон юм. Энэхүү гавьяа нь төр, засаг өндөрөөр үнэлж, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1971 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн тогтоолоор хурандаа генерал цолыг хүртээжээ. Тухайн үеийн Улсын Иргэний хамгаалалтын газар нь өдгөө Онцгой байдлын Ерөнхий газар болон өргөжин хөгжөөд байна. Энэ талаар Онцгой байдлын ерөнхий газрын харьяа, хурандаа генерал С.Равданы нэрэмжит Үндэсний аврах бригадын захирагч, хурандаа Д.Намсрай "Улс оронд иргэний хамгаалалтын үндэс суурийг тавихад чиглэгдсэн БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэр, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 10 гаруй тогтоол, олон тооны захирамж, шийдвэр гарч байснаас үзэхэд, энэхүү салбарыг бий болгоход төрөөс баримталж байсан томоохон бодлогын илэрхийлэл юм. Үүнийг хэрэгжүүлэх хүрээнд байнгын бэлэн байдлыг хангуулах, цаг үеэ дагасан шинэчлэлийг хэрэгжүүлэх, мэргэжлийн боловсон хүчнээр хангаж, дадлагажуулах зэрэг бүхий л үйл ажиллагааг хурандаа генерал С.Равдан чадварлагаар удирдан зохион байгуулж, нөр их хүч, хөдөлмөрөө зориулсан юм. Иргэний хамгаалалтын үйл ажиллагаа нь үй олноор хөнөөх зэвсэг хэрэглэсэн үед хүний амийг хамгаалах, улс орны аж ахуйн тогтвортой ажиллагааг хангах, хөнөөлт аюулын эсрэг тэмцэх, сэргээн босох хүч хэрэгслийг бэлтгэх, тэдгээрт ард иргэдийг сурган дадлагажуулахад чиглэгдэж байснаараа бүх нийтийн систем болж өнөөг хүртэл хөгжиж чадсан юм" хэмээн хурандаа генерал С.Равданы талаар түүхийг өгүүлэх "Дорнод Монголын эх оронч" номд тэмдэглэн үлдээжээ.

Монголын түүхэнд мөнхрөн үлдсэн алтан мөрдэст генералуудын түүх хойч үе болсон бидэнд олон зүйлийг ухааруулдаг жамтай. Тэдгээрийн нэгэн төлөөлөл, үзэл санаа, байр суурь нь цаг зуурын эрхэнд ганхаагүй, тууштай эх оронч үзлийг хойч үедээ өвлүүлэн үлдээсэн зүг, нийгмийн гарамгай зүтгэлтэн, цэргийн шилдэг удирдагч хурандаа генерал С.Равданы талаар ийн өгүүлжээ.

Дэд ахлагч Т.ИДЭР



тууштай тэмцэгч үзэл санаан дор нэгдэж байсан учир тухайн цаг үед өсөж торнисон үхүүхэд, залуус бага балчир наснаасаа эх оронч үзлээр хүмүүжсэн нь мэдээж. Тэдгээрийн нэг бол 1907 онд Сэцэн хан аймгийн Ачит вангийн хошуу, одоогийн Дорнод аймгийн Чойбалсан хотод А.Сандивын зургаа дахь хөвгүүн болон мэндэлсэн С.Равдан байв. Бага балчир наснаа мал маллаж, эцэг, эхийнхээ ажилд тус дэм болж байсны сацуу гэрээр бичиг, үсгийг шимтэн сурчээ. 14 нас хүрмэгц нь Ардын хувьсгалт тэмцлийн өдрүүд Монгол Улсын хэмжээнд өрнөхөд эх орныхоо тусгаар тогтнолын төлөө тууштай тэмцэгч болох замдаа эргэлт буцалтгүйгээр оржээ. Хувьсгалын салхи Монгол орныг "эргүүлж" төр, засгийг шинээр төвхнөн байгуулж, нам, олон нийтийн байгууллагууд ар араасаа гарч ирж байсан 1924 онд 17 настай залуу хөвгүүн С.Равдан орон нутагт нь байгуулагдсан залуучуудын эвлэлд сайн дураар элсэж, удалгүй Монголын хувьсгалт залуучуудын эвлэлийн III их хуралд төлөөлөгчөөр сонгогдон Нийслэл хүрээнд ирэв. Тэрээр хожмоо Хувьсгалт тэмцлийн нэрт зүтгэлтэн алдрыг хүртсэн Б.Элдэв-Очир, зохиолч Д.Нацагдорж нартай ойр дотно танилцсан ажээ. Олны

байсан гашуун бөгөөд үнэн түүх бий. Хожим С.Равданг өөрийг нь ч мөн дотнын нөхөд нь хилс хэрэгт гүжирдэж байв. Аргагүй л ямар ч буруу хэрэг үйлдээгүй, эх орноосоо урвасан нэг ч үйлдэл гаргаагүй учир яллагдаж байгаагүй талаар Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Цэргийн түүх судлалын төвийн дарга, доктор (Ph.D) хошууч Т.Сүхбаатар ярьж байв.

ДАЙНЫ ЖИЛИЙН ДАЙЧИН СОНИНЫГ ЭРХЛЭВ

Төд удалгүй дэлхий дахиныг дайны хар сүүдэр нөмрөв. Төр, засгийн удирдлагууд тухайн үеийн "Улаан од" сонины эрхлэгчийн орлогч С.Равдангийн 1932 оны баруун аймгуудад дэгдсэн зэвсэгт бослого, 1936 онд зүүн хязгаарт болсон Адаг дулаан, Булан дэрсний байлдаанд оролцож гавьяа байгуулсан туршлагыг нь бодолцон үзэж, 1939 оны Халхын голын дайны фронтод "Эх орны төлөө" нэртэй хэргийн сониныг эрхлэн гаргах үүрэг өгөв. Энэ талаар С.Равдан өөрийн дурдатгалд тэмдэглэхдээ "Халхын голын байлдааны өдрүүдэд Ардын Армийн дайчдад баатарлаг зоригийг өрнүүлэх, дайсныг үзэн ядах үзлээр хүмүүжүүлэхэд зориулан "Эх орны төлөө" сониныг гаргах болсон. Энэ сонин 1939 оны

С.Равдан байсан нь харагдаж байна. Энэ талаарх түүхийг тус сонины талаар өгүүлэх "Эх орны төлөө" номоос дэлгэрэнгүй судалж болно. Өөрөөр хэлбэл, түүний талаар бичигдсэн сонирхол татам түүхүүд элбэг. Тэдгээрийг судлах боломж бидэнд өнөөг хүртэл нээлттэй хэвээр байна.

Халхын голын байлдааны хүндэн цаг үед цэргүүдийнхээ найдвартай ар тал нь болж, эх орныхоо өмнө үнэлж баршгүй гавьяаг байгуулсан хэмээн үзэж, түүнд БНМАУ-ын Ардын Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор 1944 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр хошууч генерал цол хүртээжээ. Тэрээр 1945 оны Чөлөөлөх дайнд Монгол Ардын Хувьсгалт Цэргийн 8 дугаар дивизийг амжилттай удирдан ялалт байгуулжээ.

ДИПЛОМАТ АЛБАН ДАХЬ ОН ЖИЛҮҮД

Дэслэгч генерал Ю.Цэдэнбалын хашиж байсан Улс төрийн газрын даргын албан тушаалыг Чөлөөлөх дайны дараа хошууч генерал С.Равданд шилжүүлэв. 1945-1950 оны хооронд тэр бээр цэргийн албанаас олон мянган хүнийг халж, аж ахуй, соёлын байгууллагад шилжүүлэх, анги, нэгтгэлийг татан буулгаж, орчин цагийн Зэвсэгт хүчний үндэс суурийг тавих чиглэлээр цэргийн



ДУРСАГДАХ ГАВЬЯАТАЙ ТАНГАД БААТАР

Хөдөлмөрийн баатар, Чөлөөлөх дайнд оролцсон ахмад дайчин Түдэвийн Тангадын мэндэлсний 100 жилийн ой тохиож байна.

Тус сонин редакцияд Зэвсэгт хүчний Агаарын цэргийн түүхэнд "Элсний 13" хэмээх тодотголын эзэн буюу Сөнөөгч онгоцны анхны 13 техникчийн нэг, чөлөөнд байгаа дэд хурандаа Тангадын Цэдэндамбаа гуай ирж, аавынхаа тухай сонирхолтой баримтыг дэлгэсэн нь үүнийг тэрлэгч миний анхаарлыг гойд татаж билээ. Чөлөөнд байгаа дэд хурандаа Т.Цэдэндамбаа ЗХУ-д "МиГ-17", "МиГ-21" онгоцны хөдөлгүүрийн анхны техникчээр үр бүтээлтэй ажилласан нэгэн. Тэр бээр өөрийн мэргэжилдээ эзэн нь болсон чадварлаг техникч тул Батлан хамгаалах яамны удирдлагын түвшинд өндөрөөр үнэлэгдсэний үр дүнд 1980-1984 онд Н.Е.Жуковскийн нэрэмжит Нисэх хүчний инженерийн академид суралцан цэргийн дээд боловсрол эзэмшсэн ажээ. Ингэснээр дээрх ангид радио электрон тоноглолын инженер, ахлах инженер гэдэг албан тушаалд амжилт арвин ажилласны зэрэгцээ 1991 онд дэд хурандаа цол хүртэж 1996 онд гавьяаныхаа амралтад гарсан гэдэг.

Түүнийг аавынхаа тухай ярьж эхлэхтэй зэрэгцэн би бээр Батлан хамгаалахын төв архивын даргад хандсан юм. Энэ үед Батлан хамгаалахын төв архивын удирдлага бидний хүсэлтийг уриалгахаар хүлээн авч, нэн даруй архивын лавлагааг гаргаж өгөхөд нь "Архив гэдэг ч үнэхээр түүхэн цаг хугацааны товчоон, хэн бүхний ажил, амьдралын түүх, амжилт ололтыг нь нандинган хадгалсан их уурхай юм даа" гэж сэтгэл төрснөө нуух юун билээ.

Энэхүү архивын лавлагаанд Түдэвийн Тангадын цэргийн алба хааж, дайнд оролцож явсан тухайд холбогдох

нэрийн бүртгэлийн 36 дугаарт: "Цэрэг Түдэвийн Тангад, 1920 онд төрсөн, 19 настай, Дорнод аймгийн Баяндун сумын 8 дугаар багийн харьяат, 1939 оны 7 дугаар сарын 1-ний өдөр цэрэгт ирсэн" гэжээ. Түүнчлэн Монгол Ардын Хувьсгалт Цэргийн Нисэх дивизээс 1944 онд хугацаа дуусган халагдсан дайчдын нэрийн бүртгэлийн 33 дугаарт: "Түдэвийн Тангад, нисэх баазад цэрэгжолооч, машины жолоочийн мэргэжилтэй, 1939 оны 6 дугаар сарын 15-ны өдөр цэрэгт ирсэн, Дорнод аймгийн Баяндун сумын 8 дугаар багийн харьяат, 49 дугаарын үнэмлэхтэй халагдсан" гэсэн байлаа. Мөн Дорнод аймгийн харьяат дайчдад "Бид ялав" медаль олгосон бүртгэлийн 309 дүгээрт: "Түдэвийн Тангад, 26 настай, Баяндун сумын 4 дүгээр багийн харьяат, 1945 оны Чөлөөлөх дайнд 331 дүгээр анги (5 дугаар морьт дивизийн хуягт дивизион)-д түр цэргээр үүрэг гүйцэтгэн оролцсон учир 18764 дугаарын "Бид ялав" медаль олгосон" хэмээн бичигдсэн баримтууд байгааг лавлагаагаар тодотгосон юм.

Энд өгүүлэн буй Т.Тангад нь 1920 онд Дорнод аймгийн Баяндун сумын нутаг "Бор өндөр" хэмээх газарт малчин ард Түдэвийн 2 дугаар хүү болон мэндэлжээ. Тэр бээр бага насандаа эцэг, эхийн гар дээр өсөн хүмүүжиж, 1934-1939 онд аав, ээжийн хамтаар мал маллаж байгаад 1939 оны 6 дугаар сарын 15-ны өдөр цэргийн албанд татагдан ирсэн ба Монгол Ардын Хувьсгалт Цэргийн Жолооч нарыг бэлтгэх сургуульд 6 сар суралцан жолоочийн мэргэжил эзэмшжээ. Ингэснээр 1940 оноос Нисэх дивизэд жолооч, тасгийн даргаар хугацаат цэргийн алба хаасан байна. Улмаар 1944 оны намар цэргийн албанаас бэлтгэлээр халагдаж орон нутагтаа ирснээр өөрийн төрөлх сумынхаа 4 дүгээр багт ахлах ухуулагчийн ажлыг хийж байтал 1945 оны Чөлөөлөх дайнд түр цэргээр татагдан 5 дугаар дивизийн хуягт дивизионд жолоочоор байлдааны үүрэг



тул түүнд 11211 дугаартай Дайн, байлдаанд оролцогч ахмад дайчны үнэмлэхийг олгосны зэрэгцээ "Бид ялав" медалийг хүртээжээ. Мөн энэхүү дайны дараагаар баруун хилийн тулгаралт, байлдаанд оролцож, зоригт нисгэгч М.Зайсановын удирдсан нисэхийн бүрэлдэхүүнд үйлчлэх авто машиныг жолоодож явсан нь эргээд дурсахад нэн бахдалтай ажээ.

Дайн дуусаж, энх цаг золгохтой зэрэгцэн нийтлэлийн баатар маань төрөлх нутагтаа ирж 1945 оны намраас мөн л багийн ухуулагчийн ажлыг хийж байгаад 1946 оны хавар аймгийн намын хорооны шийдвэрээр Тээхийн 3 дугаар баазад автомашины жолоочоор ажиллаж эхэлсэн нь хожмоо дуурсагдах их үйлсийнх нь эхлэл байсан гэлтэй. Тэрээр бахархал дүүрэн ажиллаж, эрхэлсэн ажилдаа идэвх санаачилга, үр бүтээлтэй хандсаны үр дүнд 1953 оноос тус баазын гражийн даргаар, нэн удалгүй Тээврийн яамны сайдын тушаалаар Дорнод аймгийн 3 дугаар авто баазын даргаар томилогдон ажиллажээ. Энэ үед тэр бээр өөрийн хүсэлтээ гаргасны учир 1957 оноос ууган бааздаа жолоочоор ажиллаж байгаад 1980 онд өндөр насны тэтгэвэрт гарсан аж. Энэ тухайд түүний хүү Т.Цэдэндамбаа дурсахдаа "Аав маань баазын дарга хийхээсээ илүү унаган мэргэжил нь болсон жолоочийн ажлаа эрхлээд улс орныхоо хөгжилд бодит хувь нэмрээ оруулж явах шиг жаргал үгүй. Дайн, байлдаанд оролцож явсан надад цэргийн алба тийм л хүмүүжлийг олгосон доо хэмээхийг нь олонтоо сонссон" гэж хуучилж билээ.

Т.Тангадын тухайн үеийн төлөвлөгөөт норм болон ачаа тээврийн даалгаврыг тогтмол давуулан биелүүлж, бусад жолооч нараа манлайлан ажиллаж, залуу үеийг сургах, ажил, мэргэжилд нь дадлагажуулах, тэднийг төлөвшүүлэх үйлсэд оруулсан бүтээлч хөдөлмөр, идэвх зүтгэлтэй үйл ажиллагааг нь төр, засгаас өндрөөр үнэлж, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн

1971 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн зарлигаар Хөдөлмөрийн баатар хэмээх эрхэм дээд цолыг олгож, Сүхбаатарын одон хүртээжээ.

Тэрээр дээрх байгууллагад ажиллах хугацаандаа Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын депутатаар хоёр удаа сонгогдож, тухайн үеийн өндөр шалгуурыг дааж Монгол Ардын Хувьсгалт Намын 16 дугаар их хуралд төлөөлөгчөөр оролцсоноос нь харахад төрөлх аймаг, сумандаа төдийгүй өөрийн эх орондоо нэр алдар нь түгсэн алдар цуутны нэг байсан нь нэн тодорхой байна.

Ийнхүү хугацаат цэргийн албаа дүүргэсэн ч цэл залуу насныхаа ид хавыг бахдуулан цэргийн албанд дахин мордож, эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолыг харийн түрэмгийлэгчдээс батлан хамгаалах үйл хэрэгт өөрийн эрүүл мэнд, ар гэрийн аж амьдрал, алжаал ядралаа умартан зүтгэж, авто тээврийн байгууллагад он удаан жил, үр бүтээлтэй ажилласныг нь түүний энгэрт тодоос тод гялалзах баатрын алтан соёмбо, Сүхбаатарын одон илтгэсний дээр "Алтан гадас" одонг 3 удаа хүртсэнээр нь улам бүр тодотгож буй.

Энэ тухайд чөлөөнд байгаа дэд хурандаа Т.Цэдэндамбаа "Би бээр 1967 онд мөнх тэнгэрийн харуул болсон Ардын Армийн 028 дугаар ангид радиотехникийн батареины чиглүүлэх станцын оператораар хугацаат цэргийн алба хаасан. 1970 онд хойд хөршид Цэргийн нисэхийн нэгдсэн дунд сургууль төгссөнөөр 001 дугаартай байлдааны "МиГ-17" онгоцны техникчээр томилогдож, удалгүй "МиГ-21" онгоцонд шилжин суралцсанаар бүлгийн даргаар дэвшсэн. Мөн агаарын цэргийн инженерийн академийг төгсөж, эзэмшсэн мэргэжлийнхээ дагуу нисэхийн ангидаа тун ч олон жил ажилласан. Харин миний дүү Т.Жаргалсайхан 1975-1978 онд Батлан хамгаалах яамны авто граж буюу Ардын Армийн 089 дүгээр ангид, бага дүү болох Т.Эрдэнэбаатар маань 1976-1979 онд Эрдэнэтийн дивизэд хугацаат цэргийн албыг нэр төртэй хаасан. Тийнхүү ахан дүүсээрээ цэргийн алба нэр төртэй хааж, насан туршид бахархал дүүрэн агаад тэгш сайхан амьдрах өв тэгш хүмүүжлийг аавынхаа үлгэр дуурайл, үнэтэй үгс сургаал, үйлдэл бүрээс нь өвлөж авсны маань тод жишээ юм даа. Энэ мөчид аавын хамтаар 1940-1944 онд Монгол Ардын Хувьсгалт Цэргийн Нисэх дивизэд байлдааны сөнөөгч онгоцны нисгэгчээр алба хашиж явсан Дорнод аймгийн Баяндун сумын харьяат ахмад дайчид болох саятан нисгэгч Б.Бат-Очир, С.Чүлтэм гуай нарыгаа дурсахад нэн таатай байна. Аав минь хожим өндөр насныхаа тэтгэвэрт

гарсан ч гэртээ зүгээр суусангүй, өөрийн авто баазынхаа "Саятан бригад"-ын жолооч нартайгаа намрын ургац хураалт, өвс, тэжээл тээвэрлэх зэрэг олон ажилд хүчин зүтгэж явсан даа" хэмээн баяр, харууслын нулимс дүүрэн яриагаа өрнүүлж билээ.

Түүний үр хүүхдүүд аймаг, сумынхаа удирдлага, нутгийн сэтгэл нэгт ахан дүүстэйгээ хамтран Хөдөлмөрийн баатар аавынхаа гавьяат үйлсийг мөргөж мөндөрснийх нь 100 жилийн ойг тун саяхан ёслол төгөлдөр тэмдэглэсэндээ баяр хөөр дүүрэн байгаа ажээ. Энэ мөчид тэр л эрхмийн түүхэн ойг тэмдэглэхэд идэвх санаачилгатай ажилласан Зам, тээврийн хөгжлийн яам, Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газар, Авто тээврийн үндэсний төвийн хамт олонд талархсанаа илэрхийлснийг нь уламжилъя.

Түүний цэргийн алба нэр төртэй хаасан тухайд Монголын Ардын Армийн Улс Төрийн газрын орлогч дарга асан, хошууч генерал Т.Алтангэрэл "Миний бие 1939 онд Монгол Ардын Хувьсгалт Цэргийн албанд татагдаж, Нисэхийн дивизэд Т.Тангадын хамт цэргийн алба хаасан үеэ дурсаж байна. Биднийг цэргийн алба хааж байсан үед 1939 оны Халхын голын байлдаан, 1944 оны Баруун хилийн тулгаралт, 1945 оны Чөлөөлөх дайнд Монголын Нисэх хүчин оролцсон юм. Би бээр Нисэх дивизэд сургагч, сөнөөгч онгоцны эскадрилийн штабын даргын туслах, Нисэх хорооны МХЗЭ-ийн товчооны даргаар, хожим Нисэх 5 дугаар хорооны улс төрийн орлогчоор ажилласан. Намайг Цэргийн нисэх хүчинд алба хааж байх хугацаанд Т.Тангад нисэх аэродромын тусгай тоноглолын авто техникудийг чадамгай эзэмшиж, тухайн үед урт, богино зайд авто техникийн марш тактикийн тэмцээнийг зохион байгуулах үед тэргүүний жолоочоор шалгарч байлаа. Миний оны цэрэг Т.Тангад маань Цэргийн нисэх хүчнээс эхтэй бөгөөд Дорнод аймгийн Авто тээврийн 3 дугаар баазаас төрсөн анхдагч Хөдөлмөрийн баатар юм. Хамт цэргийн албанд ирж, үерхэж нөхөрлөж явсан эгэл жирийн агаад цэргийн хуарангийн анд нөхрөө бахдан хүндлэхэд таатай байна" хэмээх дурсамжаа үлдээсэн байх юм.

Ийм л бахдам амжилт, бахархалт үйлсийг нь цаг ямагт дурсаж, баатарлаг, дайчин агаад бүтээлч үйл хэргийг нь залгамжлан эх орныхоо хөгжил дэвшилд өөрийн бодит хувь нэмрээ оруулах нэн өндөр хариуцлага хойч үеийнхэнд оногдож буйг мэдрэх биз ээ гэж сэтгэлийн үүднээс Хөдөлмөрийн баатар, ахмад дайчин, Онц тээвэрчин, эгэл нэгэн жолоочийн талаар өгүүлсэн нь энэ.

Алдар нь цаг ямагт дуурсагдах ахмад үеийн гавьяат үйлс мөнх билээ.

МСНЭ-ийн шагналт сэтгүүлч, СТА, хурандаа Б.ОТГОНБАЯР



Хөдөлмөрийн баатар Т.Тангад БНМАУ-ын баатар Л.Дандарын хамт

баримтуудыг шүүн үзэхэд, Монгол Ардын Хувьсгалт Цэргийн жолоочийн сургуульд 1939 онд хуваарилагдан ирсэн дайчдын

гүйцэтгэсэн ажээ. Энэхүү Чөлөөлөх дайнд өөрийн хүлээсэн үүргээ нэр төртэй гүйцэтгэж, эрэлхэг зоригтойгоор оролцсон

САХИЛГА САЙТАЙ ГАЗАР САЙН ЖИШИГ ТОГТДОГ

(Түрүүч нь II нүүрт)

Чих тавин сонсоход "Эгч маань Зүүнбаянд ахлах тогооч хийдэг байлаа. Би эгчийндээ очиж амрахаар явсан тэр үе Зүүнбаянгийн нэгэн ойн баярын арга хэмжээтэй давхацсан юм. Тухайн үед хүүхэд байсан хэдий ч огт мартаагүй л явна. Дандар баатар тэргүүтэй Халхын голын баатруудтай нэг онгоцонд суусан тэр үеийн бүдэг бадаг зураглал санаанаас гардаггүй. "Дандар баатар аа, наад жаахан охиноо өвөр дээрээсээ алдчихав аа" гэж хэн нэгэн хэлж байсан нь одоо ч сэтгэлд тодхон. Өнөөх жаахан охин нь би. Халхын голын баатруудтай Зүүнбаянд ингэж очсон юм" гэснээр бидний яриа өндөрлөв.

ЧИ МАНАЙД ХЭРЭГТЭЙ ХҮН БАЙНА

Дараагийн онцлох цэргийн алба хаагч нь бүлгийн даргын туслах, сургагч ахлагч О.Хүрэлцэцэг. Түүнтэй ярилцах үед тэрээр эхэндээ бага зэрэг даруухан загнатар ахмад Г.Одонтуяа "За Хүрэлцэцэг минь ус залгисан юм шиг түгдчээд байх юм уу, ямар уралдаан, тэмцээнд хэрхэн амжилттай оролцсон, энэ ангийнхаа гоё сайхан гээд яриад байгаарай" гэж уриалгахан хэллээ. Түүнээс эмэгтэй хүн цэргийн алба хаагч байна гэдэг чамгүй тэвчээр шаарддаг байх гэж асуухад "Тэгэлгүй яах вэ. Ер нь эмэгтэйчүүд бид чинь эрчүүдээс илүү сэтгэлийн хаттай" гэж мөрдөстэй бүсгүйчүүдээ урамшуулж, зоригжуулав. Сургагч ахлагч О.Хүрэлцэцэгт спортын суурь



Сургагч ахлагч О.Хүрэлцэцэг

сайн тавигдсан гэдгийг өөрөөс нь сонслоо. Энэ нь ч цэргийн мэргэжлийн хүн болох замыг нь дөтөлсөн биз. Тэрээр "Аав үндэсний бөх, ээж маань хөнгөн атлетикийн спортоор хичээллэдэг байсан. Би мөн ээжтэйгээ адил багаасаа хөнгөн атлетикаар хичээллэж эхэлсэн. Олон ч тэмцээн уралдаанд оролцож амжилт үзүүлдэг байлаа. Ингэж явахдаа нэг удаа шүүхийн шийдвэрийн хувцас өмссөн ахмад цолтой эгчийг хараад цэргийн хүн болчихвол ямар гоё вэ гэсэн бодол төрж билээ. Биеийн тамирын сургуулийг төгсөөд тус ангид энгийнээр

ажиллаж эхэлсэн. Нэгэн удаа тэмцээнд оролцоод ирсний дараа ангийн удирдлагууд "Чи манайд тун хэрэгтэй хүн байна, чамайг ахлагчийн албанд улирааж авна" гэж хэлсэн. Ингээд сарын дараа цолоо авсан. Үе үеийн удирдлагууд маань тусалж, дэмждэгт талархдаг" гэлээ. Үнэхээр ч тэр үеийн ухаалаг дарга нарын шийдвэр нүдээ олсон гэдгийг сургагч ахлагч О.Хүрэлцэцэг амжилт, бүтээлээрээ батлан харуулсаар байгаа аж. Түүний хувьд 2001 оноос радио телеграфын спортоор хичээллэж 2008 онд олон улсын хэмжээний мастерын болзлыг хангажээ. Мөн Ази тивийн хоёр удаагийн аварга болсноос гадна дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд хоёр удаа шандсаа соринд амжсан байна.

Нар шингэхтэй зэрэгцээд сурвалжлах ажил ч шувтрав. Ингээд буцахаар зэхэхэд ангиас унаа гаргаж өгөхөөр боллоо. Зорьсон газарт маань саадгүй хүргэсэн жолооч бол холбооны техникч, тусгай техникийн засварын дарга-жолооч, ахлагч М.Бямбацогт. Түүний аав бэлтгэл дэд хурандаа Г.Мөнхжаргал нэгэн цагт энэ ангийн шашины даргаар ажиллаж байсан гэнэ. Ахлагч М.Бямбацогт аавынхаа буурийг сахиж Зэвсэгт хүчний 124 дүгээр ангид алба хааж байгаагаа бас л хувь тохиол гэж боддог. Тэрээр үргэлжлүүлэн сүүлийн жилүүдэд алба хаах орчин, нөхцөл нь сайжирсныг хэд хэдэн жишээгээр дурдаж байлаа. Зорьсон газраа ирээд жолоочид хариу талархал илэрхийлж бууснаар сурвалжилга маань өндөрлөв.

Дэслэгч Ц.ЭНХ-ОРГИЛ

